

ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН ТЕХНИК АШИГЛАЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

1.1 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын үйл ажиллагаанд техник ашиглалтын улмаас аюул осол гарахаас сэргийлэх, хүрээлэн байгаа орчинд учирч болох эрсдэлийг багасгах, бүтээгдэхүүний чанарыг хадгалах, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй нөхцөлийг хангахад нь энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2 Энэ дүрмээр газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ, эдэлбэр газрын ашиглалтад тавигдах ерөнхий шаардлагууд, газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, ачих үйл ажиллагааны технологийн горим, галын болон экологийн аюулгүй байдлын шаардлага, ажиллагсдын үүргийг тогтооно.

1.3 Газрын тос олборлолтын зориулалтын агуулах, шингэрүүлсэн хийн агуулах, 700 мм мөнгөн усны баганаас дээш харимхай чанар бүхий уур үүсгэдэг бүтээгдэхүүн хадгалах агуулахад энэхүү дүрэм хамаарахгүй.

1.4 Энэ дүрэм нь монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахуудад хамаарна.

1.5 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын удирдах байгууллага (удирдлага), энэхүү дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах ажил хариуцсан ажилтан дүрмийн заалтыг биелүүлэх үүрэгтэй бөгөөд дүрмийг биелүүлээгүйгээс шалтгаалан гарсан аливаа зөрчил, хохиролд хариуцлага хүлээнэ.

1.6 Энэхүү дүрмийн хэрэгжилтэд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, онцгой байдлын байгууллага, бусад эрх бүхий хяналтын байгууллагууд хяналт тавина.

1.7 Эрх бүхий байгууллагаас баталсан бусад холбогдох дүрэм, журам, стандартыг дагаж мөрдөхийг энэхүү дүрмээр хязгаарлахгүй, аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг илүү бууруулах зорилгоор энэхүү дүрмийн заалтуудтай зөрчилдөх шинэ эрхийн акт батлахад энэхүү дүрмээр хориглохгүй.

1.8 Энэхүү дүрэмд тусгайлан заагаагүй, аливаа тоног төхөөрөмж, барилга байгууламжийг ашиглахдаа тухайн салбарын болон, үйлдвэрлэгч байгууллагаас гаргасан ашиглалтын дүрэм, зааврыг баримтална.

1.9 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд төмөр зам, автотээврээс бусад төрлийн тээвэр (усан зам, дамжуулах хоолой, агаарын тээвэр зэрэг) ашигладаг агуулахын хүлээн авах, олгох ажиллагаанд тухайн төрлийн тээврийн холбогдох, дүрэм зааврыг баримтална.

Хоёр. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

2.1. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын тодорхойлолт

2.1.1. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнийг (цаашид бүтээгдэхүүн гэх) хүлээн авах, хадгалах, бөөнөөр олгох үйл ажиллагааг гүйцэтгэхэд зориулагдсан барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж хэрэгслийн цогцолборыг газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах (цаашид агуулах гэх) гэнэ.

2.1.2. Хуулийн этгээд, эсхүл хуулийн этгээдийн салбар нэгж холбогдох хууль тогтоомж, эрхийн актуудын хүрээнд агуулахын үйл ажиллагааг эрхэлнэ.

2.1.3. Агуулахын үндсэн үзүүлэлт нь нийт багтаамж, жилийн ачаа эргэлт, савны ашиглалт, савны дүүргэлтээр илэрхийлэгдэнэ.

2.1.4. Агуулахыг нийт багтаамжаас хамааруулж БНБД 21-03-04 “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах. Галын аюулгүйн норм”-ын дагуу зэрэглэнэ. Үүнд:

Газрын тос, газрын тосны агуулахын зэрэглэл

Агуулахын зэрэглэл	Нэг савны багтаамжийн дээд хэмжээ, м ³	Агуулахын нийт багтаамж, м ³
I	-	50001 – дээш
II	-	20001- 50000
IIIa	5000 болон доош	10001- 20000
IIIб	2000 болон доош	2001- 10000
IIIв	700 болон доош	2000- болон доош

Агуулахын нийт багтаамж нь саванд хадгалагдах болон жижиглэн савласан бүтээгдэхүүний эзлэхүүнүүдийн нийлбэр хэмжээгээр тодорхойлогдоно. Савны багтаамжийг нэрлэсэн багтаамжаар тодорхойлно.

Нийт багтаамжийг тодорхойлоход дараах савнуудыг оруулж тооцохгүй. Үүнд:

- ачиж буулгах байгууламжийн хүлээн авах (0-ийн) сав
- халаалтын зуухны болон дизель цахилгаан үүсгүүрт хэрэглэх түлшний зориулалтын 100 м³-ээс бага багтаамж бүхий савнууд;
- илүүдэл, хаягдлыг цуглуулах савнууд;
- ашигласан тос хүлээн авах савнууд (савны паркийн гадна орших)
- цэвэрлэх байгууламж дахь бохирдсон уснаас ялган авсан газрын тосны бүтээгдэхүүн цуглуулах сав,

2.2. Агуулахын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний нийтлэг зохион байгуулалт, тэдгээрийн ерөнхий шаардлага

2.2.1. Агуулахын үндсэн үйл ажиллагаа нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, бөөнөөр олгох үйл ажиллагааг осол аюулгүйгээр сааталгүй гүйцэтгэх, үйл ажиллагааны явцад бүтээгдэхүүний чанарыг хадгалах, алдагдлыг хамгийн бага хэмжээнд байлгахад чиглэгдэнэ. Агуулахад бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, олгох, хэмжилт тооцоололт хийх технологийн үйл ажиллагааг MNS 4633:2006 “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачлал” стандарт болон бусад холбогдох норм, дүрэм, журмын дагуу гүйцэтгэнэ.

2.2.2. Агуулахын технологийн байгууламж, тоног төхөөрөмж нь БНБД 21-03-04 “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах. Галын аюулгүйн норм”, MNS 5746:2007 “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах. Технологийн байгууламж. Техникийн ерөнхий шаардлага” стандарт бусад холбогдох норм стандартын шаардлагыг хангасан, ашиглалтын нөхцөлд тохирсон байна. Технологийн тоног төхөөрөмжүүд газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний технологи үйл ажиллагаанд зориулагдсан, **нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн** байна.

2.2.3. Агуулахыг тухайн төв суурин газрыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн тусгай талбайд БНБД 21-03-04 “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах. Галын аюулгүйн норм”-ын дагуу орчны барилга байгууламжаас тогтоосон зайд байрлуулна. Агуулах бүр нь газар ашиглах эрхийн баримт бичигтэй байна.

2.2.4. Шинээр баригдсан, өргөтгөл шинэчлэл, их засвар хийсэн барилга байгууламжийг холбогдох дүрэм, журмын дагуу туршиж албан ёсоор ашиглалтад хүлээн авсны дараа ашиглана.

2.2.5. Агуулахын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын горим, засвар үйлчилгээ, техникийн үзлэг, оношилгоог тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн баримт бичиг, ашиглалтын заавар, бусад холбогдох норм дүрмийн шаардлагын хүрээнд зохион байгуулна.

2.2.6. Агуулахын байнгын хүн ажиллах өрөө тасалгааны температур, чийгшил, гэрэлтүүлэг, агааржуулалт зэрэг хөдөлмөрийн нөхцөл нь холбогдох стандартын шаардлагыг хангасан байна. Үйлдвэрлэл, технологийн зориулалтын байр, өрөө тасалгааны нөхцөл нь тухайн байранд тавигдсан тоног төхөөрөмжийн ашиглалтын шаардлага, технологийн үйл ажиллагааны горимоос хамаарна.

2.2.7. Үйлдвэрлэлийн болон бусад барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн байдал, ялангуяа дээвэр, суурь зэрэг динамик ачаалалд өртөгдөж байдаг бүтцүүдийн байдалд байнгын хяналт тавьж, тэдгээрт ямар нэгэн эвдрэл, гэмтэл, согог гарвал түүнийг нэн даруй засна.

2.2.8. Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг паспортод заасан үзүүлэлтээс хэтэрсэн нөхцөлөөр ашиглахыг хориглоно.

2.2.9. Технологийн тоног төхөөрөмжийн үзүүлэлтэд өөрчлөлт орох тохиолдолд зураг төслийн зохиогчтой зөвшилцөнө.

2.2.10. Барилга байгууламжийн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулах бол зураг төсөл зохиосон байгууллагатай зөвшилцөх буюу шинээр зураг төсөл зохиолгоно.

2.2.11. Сав, тоног төхөөрөмж, технологийн хоолой бусад технологийн байгууламжуудын ашиглалтын нөөцийг агуулахын паспортод бичсэн байна.

2.2.12. Агуулахын удирдлага барилга байгууламж, тоног төхөөрөмжийн үзлэг, оношилгоо, засвар, улирлын үйлчилгээний төлөвлөгөө, график баталж мөрдөнө.

2.2.13. Агуулахын үйл ажиллагааг явуулах, ашиглалтыг зохион байгуулахад мөрдөгдөх шаардлагатай бүх эрх зүйн баримт бичгүүдийн санг бүрдүүлнэ.

2.2.14. Агуулахуудад дараах баримт бичгүүд хөтлөгдөнө. Үүнд:

- агуулахын техникийн паспорт
- агуулахын иж бүрэн зураг төсөл
- барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн үзлэг, засварын бүртгэл
- газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савны паспорт
- барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн паспорт, ашиглалтын заавар,
- технологийн үйл ажиллагааны горим,
- засварын ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны зааврууд
- технологийн үйл ажиллагаа явуулах тухай шийдвэрийн бүртгэл
- савнуудын онооллын хүснэгт
- барилга байгууламжуудын ашиглалтын паспорт
- агуулахын удирдлагын шийдвэрийн дагуу бусад баримт бичиг

2.2.15. Тоног төхөөрөмжийн үзүүлэлт техникийн баримт бичигт зааснаас зөрж байгаа тохиолдолд ашиглаж болохгүй.

2.2.16. Агуулахын технологийн тоног төхөөрөмж, технологийн хоолой, хийн хоолойг туршилт, шалгалт, оношилгоо хийх боломжтой байна.

2.2.17. Тоног төхөөрөмжийн ашиглалтын нормт хугацаа дууссан техникийн оношилгоо, магадалгаа хийж ашиглалтын нөөцийг тогтооно.

2.2.18. Засвар угсралтад ашиглах материалууд техникийн шаардлагад тохирсон, чанарын гэрчилгээтэй байна.

2.2.19. Агуулахын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тухайн төрлийн тоног төхөөрөмжийн талаар мэргэшсэн ажилтан гүйцэтгэнэ.

2.2.20. Цахилгаан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, цахилгаан хөдөлгүүр бүхий төхөөрөмжийг ажиллуулах ажилтнууд цахилгаан техникийн аюулгүй ажиллагааны холбогдох дүрэм журмын дагуу сургалтад хамрагдаж мэргэшсэн байна.

2.2.21. Тэсрэлтийн аюултай хий хуримтлагдсан орчинд засварын ажилд бэлтгэх гүйцэтгэхэд болон гал хэрэглэсэн ажил гүйцэтгэхэд тэсрэлтийн аюултай бүсэд гал хэрэглэсэн засварын ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны журмыг баримтална.

2.2.22. Тэсрэлтийн аюултай бүсэд засварын ажил гүйцэтгэхэд оч үсрэхээс хамгаалсан багаж ашиглана.

2.2.23. Засварын ажлыг мэргэжлийн өөр байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд ажиллагсдыг агуулахын аюулгүй ажиллагааны сургалтад хамруулж, аюулгүй ажиллагаанд хяналт тавих ажилтанг томилно.

2.2.24. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хадгалалтад шилжүүлэх арга хэмжээг холбогдох зааврын дагуу зохион байгуулна.

2.2.25. Газар дээр болон газар доорх металл хийц, байгууламжуудыг холбогдох норм дүрмийн дагуу зэврэлтээс хамгаалах түрхлэг буюу бусад арга хэрэгслээр зэврэлтээс хамгаална.

2.2.26. Ашиглалтын үед газар дээрх металл хийцийн зэврэлтийн хамгаалалтыг гадна үзлэгээр буюу хүчдэлийг хэмжих аргаар, газар доорх металл хийцийнхийг зөвхөн хүчдэлийг хэмжих аргаар шалгана.

2.2.27. Зэврэлтээс хамгаалах цахилгаан химийн арга хэрэглэж байгаа тохиолдолд туйлшралын потенциалыг хэмжих тоног төхөөрөмж суурилуулна.

2.2.28. Зэврэлтийн хамгаалалтын шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

2.2.29. Агуулахын технологийн үйл ажиллагаа явуулдаг байрууд холбогдох норм дүрмийн шаардлага хангасан, зураг төслийн дагуу холбооны хэрэгсэлтэй байна.

2.2.30. Хүйтний болон дулааны улирал шилжих үед агуулахын хэвийн, тасралтгүй ажиллагааг хангахад чиглэгдсэн техникийн арга хэмжээний төлөвлөгөө гаргана. Төлөвлөгөөнд технологийн тоног төхөөрөмж, барилга байгууламжууд, эрчим хүч, ус хангамжийн систем, бохир усны систем зэрэгт хийх ажлуудыг тусгана. Өвлийн улиралд ашиглагдахгүй тоног төхөөрөмж барилга байгууламжийг хадгалалтад шилжүүлэх арга хэмжээ авна.

2.2.31. Бүтээгдэхүүнийг жижиглэн савлаж олгох ажиллагааг тусгай төхөөрөмжилсөн байр, талбайд зориулалтын төхөөрөмжийг ашиглан гүйцэтгэнэ. Жижиглэн савлах, савласан бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгсэлд ачих үйл ажиллагааг тусгайлан батласан заавар, журмын дагуу зохион байгуулна.

2.2.32. Агуулахын халаалтын системийг зураг төслийн дагуу байгуулж холбогдох нийтлэг дүрэм зааврын хүрээнд ашиглалтыг зохион байгуулна.

2.3. Аюулгүй ажиллагааг хангах

2.3.1. Агуулахын удирдлага галын аюулгүй байдал, экологийн аюулгүй байдал, эрүүл ахуй хөдөлмөр хамгаалал, бусад аюулгүй ажиллагааны холбогдолтой хууль дүрмүүдийн хэрэгжүүлэх, шаардлагуудын биелэлтэд байнгын хяналт тавих, эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд шуурхай мэдээлэх ажлыг зохион байгуулж түүнд шаардлагатай багаж хэрэгсэл, ажиллах хүчээр хангана.

2.3.2. Аюултай нөхцөл үүсэх, гал гарах, бүтээгдэхүүн асгарах зэрэг аваар осол гарах тохиолдолд хор хөнөөлийг багасгах, ажиллагсдын амь нас эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн авах арга хэмжээний төлөвлөгөөг баталж энэ талаар ажиллагсдыг дадлагажуулах, шаардлагатай материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх хэрэгтэй.

2.3.3. Мөн тодорхой үечлэлээр агуулахын барилга байгууламж, технологийн үйл ажиллагааны аюулгүй байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах арга хэмжээ зохион байгуулна.

2.3.4. Аюулгүй ажиллагааг хангуулах талаар төрийн эрх бүхий байгууллагуудын хууль ёсны шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ёстой.

2.3.5. Аюулгүй ажиллагааг хангахын тулд дараах арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай. Үүнд:

- зураг төсөлд туссан техникийн шийдлийг хэрэгжүүлэх
- технологийн үйл ажиллагааны горим, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг биелүүлэх
- техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг аюулгүй зохион байгуулах

- ажиллагсдын мэргэжлийн сургалтын системийг буй болгох
- 2.3.6. Аваар, ослоос сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:
- технологийн үйл ажиллагааг удирдах болон аваараас хамгаалах автомат систем ашиглах,
 - тоног төхөөрөмж, техник хэрэгслийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засварыг тогтмол зохион байгуулах,
 - үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлөх аюултай хүчин зүйлүүдийн хяналтын систем бий болгох,
 - гарсан аваар осол, аваар осол гарахад дөхсөн үйлдэл, нөхцөл байдлын талаар мэдээллийн сан буй болгож дүгнэлт хийж байх,
 - аваар осол үүсэхийг сануулах арга хэмжээ зохион байгуулах
- 2.3.7. Тэсрэлтийн аюултай орчин үүсэхээс хамгаалах арга хэмжээ:
- хялбар асах болон шатамхай шингэний технологийн үйл ажиллагааг автоматжуулах,
 - тоног төхөөрөмжийн хугацаанаас өмнөх элэгдэл, эвдрэл үүсэхээс хамгаалах зориулалтын техникийн арга хэмжээ зохион байгуулах,
 - ашиглалтын үед тэсрэлтийн аюултай хий, шингэн алдагдах эрсдэл ихтэй хэсэг, зангилаа, холболтуудыг тогтмол хяналтад байлгах,
 - аюултай бүсүүдэд тэсрэлтийн аюултай хий, шингэний алдагдлыг эхний үед илрүүлэх, мэдээлэх, улмаар тоног төхөөрөмжийн ажиллагааг зогсоох арга хэрэгсэл ашиглах,
 - тэсрэлтийн аюултай хийг хаях хэмжээг хамгийн бага түвшинд байлгах техник хэрэгсэл ашиглах,
 - хялбар асах, шатамхай бүтээгдэхүүний ууршилтыг хамгийн бага түвшинд байлгах техник, технологи ашиглах,
- 2.3.8. Тэсрэлтийн аюултай орчинд галын эх үүсвэр үүсэхээс хамгаалах арга хэмжээ:
- тэсрэлтийн болон галын аюултай бүсүүдэд тухайн орчинд зориулагдсан, хамгаалагдсан цахилгаан төхөөрөмжийг ашиглах,
 - аюултай статик цэнэгжилтээс хамгаалах шаардлага хангасан технологийн горим, тоног төхөөрөмж ашиглах,
 - оч үсэргэдэггүй багаж хэрэгсэл ашиглах,
 - галын эх үүсвэр болох магадлалтай төхөөрөмжүүдийг түргэн унтраах хэрэгсэл ашиглах,
 - тоног төхөөрөмж, техник хэрэгслийн халдаг, бүтээгдэхүүн хүрэх магадлалтай хэсгүүдийн халалтын температурт хяналт тавих,
 - тоног төхөөрөмж барилга байгууламжийн аяндын хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хянах,
- 2.3.9. Агуулахын технологийн үйл ажиллагааг (ачих, буулгах, сав сэлгэх зэрэг) хариуцсан албан тушаалтны шийдвэрийн дагуу эхэлнэ. Бүх технологийн үйл ажиллагаа, шийдвэр, ажилтанд өгсөн үүрэг даалгавруудыг “Технологийн үйл ажиллагаа явуулах тухай шийдвэрийн бүртгэл”-д тэмдэглэх шаардлагатай.
- 2.3.10. Үйлдвэрлэлийн үе шат, хэсэг нэгж, барилга байгууламж бүрт тэдгээрийн онцлогийг тусгасан галын аюулгүйн дүрэм, аюулгүй ажиллагааны зааварчилга, галын аюулын үед ажиллах төлөвлөгөө байна.
- 2.3.11. Гал унтраах барилга байгууламж, галын дохиолол мэдээллийн системийг холбогдох норм, зураг төслийн дагуу байгуулж байнгын бэлэн байдалд байлгана. Гал гарсан үед галын байгууллагатай холбогдох найдвартай хэрэгсэлтэй байна.
- 2.3.12. Агуулахын ажиллагсад өөрсдийн гүйцэтгэх ажлын талаар мэргэшсэн, эрүүл мэндийн шаардлагыг хангаж байх ёстой. Удирдлагаас тусгай төлөвлөгөөний дагуу ажиллагсдыг аюулгүй ажиллагааны сургалтад хамруулж дадлагажуулж байна.
- 2.3.13. Технологийн үйл ажиллагааны дамжлага, аюултай ажилд ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын зориулалтын хувцас, хамгаалах хэрэгсэл, тусгай зориулалтын багаж хэрэгслээр хангана.

2.3.14. Тэсрэлтийн орчин үүсэх магадлалтай ажлын байранд ажиллагсад цэнэгжихээс хамгаалагдсан хувцас, гутал хэрэглэнэ.

2.3.15. Оч үсэргэж болзошгүй эд зүйлийг тэсрэлтийн аюултай бүсүүдэд түр байрлуулахдаа унахаас сэргийлэх хэрэгтэй.

2.3.16. Сав, технологийн худгууд зэрэг бүтээгдэхүүний уур байх магадлалтай байгууламж дотор үзлэг хийхдээ амьсгалын эрхтнийг хамгаалах хэрэгсэл ашиглана.

2.3.17. Агуулахад зөвшөөрөлгүй гадны хүн орох, агуулахын ойр орчинд ямар нэг аюултай ажил гүйцэтгэхээс хамгаалах арга хэмжээ авна.

2.3.18. Ажиллагсад барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн эвдрэл гэмтэл, дүрэм зааврын зөрчлийн талаар удирдлагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

2.4. Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, хаягдлын бодлого

2.4.1. Агуулахад орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль дүрмийн хүрээнд тухайн орон нутаг, нөхцөл цаг уурын байдалд тохирсон арга технологийг ашиглаж байнга сайжруулж ажиллана.

2.4.2. Агуулахын удирдлага бүтээгдэхүүний ууршилтыг багасгах, хөрс, усыг бохирдуулахаас сэргийлэх, хог хаягдлыг бууруулах, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор “Орчныг бохирдлоос сэргийлэх төлөвлөгөө (хөтөлбөр)” боловсруулж хэрэгжүүлнэ.

2.4.3. Хаягдлын бодлого нь орчны бохирдлоос сэргийлэхэд гол үүрэгтэй бөгөөд агуулахын удирдлага дараах чиглэлийн арга хэмжээг тусган төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

- хаягдал гарах эх үүсвэрийг багасгах (тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг сайжруулах, сургалт зохион байгуулах, тоног төхөөрөмж, технологийг шинэчлэх, , г.м)

- хаягдлыг дахин ашиглах (дахин боловсруулж ашиглах г.м)

- хаягдлыг хоргүйжүүлэх (механик, хими, биологийн зэрэг арга технологиор хаягдлыг хоргүйжүүлэх г.м)

- зайлуулах, устгах (зөвшөөрөгдсөн газарт хаях, устгах г.м)

2.4.4. Агуулахын үйл ажиллагааны явцад гарах хаягдлыг дараах үндсэн 4 ангилалд хувааж үзэх ба хаягдлын бодлогын тухайн чиглэл тус бүрээр хэрэгжүүлнэ: Үүнд:

- технологийн үйл ажиллагааны хаягдал

- цэвэрлэх байгууламжийн хаягдал

- тээврийн хэрэгслийн хаягдал

- аж ахуйн хаягдал

2.4.5. Технологийн үйл ажиллагааны хаягдал:

- бүтээгдэхүүнийг хадгалах, ачих буулгах үйл ажиллагааны үеийн ууршилт,

- техникийн эвдрэл гэмтэл, үйл ажиллагааны алдаанаас гарсан асгалт, гоожилт, шүүрэлтээс гарах бүтээгдэхүүн, бохирдсон хөрс

- бүтээгдэхүүний холилт, чанарын алдагдлаас гарсан хаягдал, савны үлдэгдэл,

- сав, шүүлтүүр, шугам хоолой, технологийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээнээс гарах бохирдсон ус, лаг, арчих материал,

- лабораторын хаягдал

- хийн буцаах, хувиргах төхөөрөмжийн хаягдал

- савны бүтээгдэхүүн доорх ус, тунадас

- гидростатик шалгалтад ашигласан бохирдсон ус,

- бүтээгдэхүүнээр бохирдсон хурын ус

- тоног төхөөрөмжийн эвдэрсэн эд анги, бусад хог

2.4.6. Цэвэрлэх байгууламжийн хаягдал:

- тос ялгагч, цэвэрлэх байгууламж, төхөөрөмжөөс гарах хаягдал,
- ууршуулагч талбай, цэвэрлэх байгууламжаас уурших бүтээгдэхүүн
- ууршуулагч талбайн үлдэгдэл лаг
- байгууламжин засвар үйлчилгээнээс гарах бусад хаягдал,

2.4.7. Тээврийн хэрэгслийн хаягдал

- хөдөлгүүрийн ажилласан тос
- торхны
- хуучин дугуй, эвдэрсэн эд анги

2.4.8. Аж ахуйн хаягдал:

- сав баглаа боодлын хаягдал
- хүнсний хаягдал
- ахуйн хог
- уурын зуухны хаягдал
- халаалтын системийн бохирдсон ус

2.4.9. Агуулахын удирдлага нь технологийн үйл ажиллагааны явцад ууршилтаас агаарт хаягдаж байгаа бүтээгдэхүүний хэмжээг багасгахад чиглэгдсэн техник зохион байгуулалтын арга хэмжээг байнга авах, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэг хүлээнэ.

2.4.10. Гадаргуугийн болон хөрсний усны бохирдлоос сэргийлэх үүднээс агуулахын үйлдвэрлэлийн хаягдал ус болон бохирдсон хурын усыг цэвэрлэх ёстой. Усыг цэвэршүүлэх түвшин нь бохирдуулагч бодисын тогтоосон зөвшөөрөгдөх дээд агууламжийн норм, бохирдсон усыг зайлуулж буй нөхцөлөөс хамаарна.

2.4.11. Хаягдал усан дахь бохирдуулагч бодисын агууламжийг багасгахын тулд хаягдал усны хэмжээг багасгах, цэвэршүүлэлтийн түвшинг өндөржүүлэх арга хэмжээ авна. Усны хаягдлыг багасгах зорилгоор хаягдал усыг үйлдвэрлэлд дахин ашиглах, үйлдвэрлэлийн усны хэрэглээг бууруулах ба тоног төхөөрөмж, холболтуудын битүүмжлэлийг хангаж газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний гоожилт, алдагдлыг арилгах замаар усанд хаягдах бохирдуулагч бодисын хэмжээг багасгана.

2.4.12. Хаягдал усанд байгаа бохирдуулагч бодисын агууламж, хаягдал усны хэмжээг хянах ажиллагааг агуулахын удирдлага холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулна.

2.4.13. Аваар ослын байдлаар асгарсан бүтээгдэхүүнийг тархахыг хязгаарлах, цуглуулах системийг холбогдох норм, дүрмийн дагуу байгуулж ашиглана.

2.4.14. Бүтээгдэхүүнийг халиулахаас сэргийлэх зорилгоор халилтаас хамгаалах хэрэгсэл ашиглана.

Гурав. ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Бүтээгдэхүүнийг хүлээн авах, олгох

Вагонцистернээс хүлээн авах, ачих

3.1.1. Бүтээгдэхүүнийг вагонцистернээс буулгах, ачих үйл ажиллагааг тухайн зориулалтаар холбогдох норм дүрмийн хүрээнд, зураг төслийн дагуу байгуулсан ачих буулгах байгууламж дээр гүйцэтгэнэ. Буулгах, ачих үйл ажиллагааны горим ачих буулгах тоног төхөөрөмжийн төрөл, хүчин чадал, вагонцистерний буулгах болон ачих хэрэгслийн төрөл, бүтээгдэхүүний шинж чанар, цаг агаарын нөхцөл зэргээс хамаарна. Агуулахын удирдлага өөрийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний төрөл, нөлөөлж болох бусад хүчин зүйлүүдийг үндэслэн энэхүү дүрэм бусад холбогдох дүрэм заавруудын дагуу ачих буулгах технологийн горимыг баталж мөрдүүлнэ

3.1.2. Ачих буулгах хэрэгсэл, ачих гар, технологийн хоолой нь бүтээгдэхүүний төрлүүд холигдохоос бүрэн хамгаалагдсан хийц, арга хэрэгсэлтэй, бүрэн суллагдах боломжтой, байна. Онгоцны түлшийг хэрэглэгчид ачихад тусгай ачих гар, мөстөлтөөс хамгаалах шингэн, цайралтаас хамгаалах шингэнийг хүлээн авахад тусгай төхөөрөмж, хоолой, насос ашиглана. Хортой бодисын I болон II ангилалд хамаарах бүтээгдэхүүнийг битүүмжилсэн аргаар ачиж буулгана. Этилжүүлсэн бензинийг хүлээн авах, ачихад зөвхөн тусгай зориулалтын хоолой, хэрэгсэл ашиглана.

3.1.3. Вагонцистерний доогуур буулгахдаа насосоор саванд шахах, урсгалаар хүлээн авах, саванд юүлэх аргуудыг хэрэглэнэ. Дээгүүр буулгаж байгаа тохиолдолд вагонцистернийг бүрэн буулгах үүднээс өөрөө сорох насос, вакуум насос, гүний насос зэргийг ашиглана.

3.1.4. Бүтээгдэхүүнийг ачих, буулгах үйл ажиллагааны дээд хурд нь бүтээгдэхүүний шинж чанар, дамжуулах хоолой, ачиж буулгах хэрэгслийн материалын үзүүлэлтээс хамаарах бөгөөд аюултай статик цэнэгжилтээс хамгаалах тухай холбогдох заавар журамд зааснаас хэтэрч болохгүй. Ачиж буй насосын гаралт талаас орох тал руу бүтээгдэхүүний зарим хэсгийг шилжүүлэх замаар ачих хурдыг хязгаарлана.

3.1.5. Тээврийн хэрэгсэлд ачиж байгаа бүтээгдэхүүний температур холбогдох дүрэм, зааварт зааснаас хэтэрч болохгүй.

3.1.6. Өндөр зунгалагтай халаасан бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгсэлд ачихад аюулгүйн техникийн дүрэм буюу техникийн нөхцөл, ачаа тээвэрлэх журмаар зөвшөөрөгдсөн температурт гүйцэтгэвэл зохино.

3.1.7. Ачих, буулгах технологийн үйл ажиллагааг хариуцсан албан тушаалтны шийдвэрийн дагуу эхэлнэ. Бүх технологийн үйл ажиллагаа, шийдвэр, ажилтанд өгсөн үүрэг даалгавруудыг “Технологийн үйл ажиллагаа явуулах тухай шийдвэрийн бүртгэл”-д тэмдэглэх ёстой.

3.1.8. Ачилт, буулгалтыг эхлэхээс өмнө ачих, буулгах төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгаж илэрсэн гэмтлийг арилгана.

3.1.9. Доогуур ачих, буулгах төхөөрөмжийн цистернд холбох хэрэгсэл оч үсэргэхгүй металлээр хийгдсэн цистерний холбох хэрэгсэлд таарч битүүмжлэл хангаж найдвартай, бөх бат холболт үүсгэдэг байх ёстой. Төхөөрөмжийг холбож холболтыг нарийвчлан шалгасны дараа ачих, буулгах ажиллагааг эхэлнэ.

3.1.10. Ачих буулгах гар түргэн хаах хэрэгсэлтэй байх ба тэр нь автомат систем бол ачих ачааны хэмжээ гүйцсэн, вагонцистерний дүүргэлтийн дээд түвшин хүрсэн тохиолдолд ачилтыг зогсоох ёстой.

3.1.11. Аварын үед хаах зориулалтын удирдлагатай түргэн хаах хэрэгслийг ачих буулгах байгууламж руу очиж байгаа хялбар асах болон шатамхай шингэний хоолойд, байгууламжаас 20-50 м-ийн зайд тавина. Удирдлагыг операторын байр болон тавцанд гарах шатны дэргэд байрлуулна.

3.1.12. “А” ангиллын агуулахын вагонцистернд ачих буулгах төхөөрөмж нь хийг буцаах (цуглуулах) системд холбогдсон битүүмжилсэн аргаар буулгах боломжтой байна. “А”, “Б” ангиллын агуулахын вагонцистернд ачих буулгах төхөөрөмжийг халилтаас хамгаалах хэрэгслээр тоноглоно.

3.1.13. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх вагонцистерн, автоцистерн, бусад тээврийн хэрэгслүүд нь зориулалтын, холбогдох стандартын шаардлагыг хангасан, ачих буулгах зориулалтын хэрэгсэлтэй, эвдрэлгүй бүрэн бүтэн байх ёстой.

3.1.14. Буулгах төхөөрөмжийг вагонцистерний хүйсэнд холбож битүүмжлэгдсэн аргаар бүтээгдэхүүнийг буулгана. Зориулалтын төхөөрөмж ашиглан бүтээгдэхүүнийг дээгүүр буулгаж болно. 120°C хэмээс дээш дүрсхийх температур /температура вспышки, flash point/ бүхий бүтээгдэхүүнийг төмөр замын дор буюу дэргэд байрласан саванд задгайгаар гоожуулж буулгахыг зөвшөөрнө.

3.1.15. Бүтээгдэхүүнийг хүлээн авах, олгох үйл ажиллагааг хариуцаж байгаа ажиллагсад дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- технологийн байгууламж, тоног төхөөрөмжийн байрлал, бүтэц, үзүүлэлт, ашиглалт үйлчилгээний зааврыг мэддэг байх,
- хүлээн авах, олгох үйл ажиллагаа гүйцэтгэхэд технологийн схемийг ашиглах мэдлэгтэй байх, агуулахын удирдлагаас өгсөн технологи үйл ажиллагааны шийдвэрийг хэрэгжүүлэх чадвартай байх,
- хүлээн авах, хадгалах, олгох үеийн бүтээгдэхүүний хэмжилтийг хийх чадвартай байх,
- технологийн үйл ажиллагааны явцад бүтээгдэхүүний чанар алдагдахаас сэргийлэх,

3.1.16. Аянга цахилгаантай үед буюу 15 м/с-ээс илүү салхитай үед ачих, буулгах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Аянга цахилгаантай үед вагонцистерний люкийг хаасан байна.

3.1.17. Ажлын талбайд үзэгдэх орчин хязгаарлагдсан, хальтаргаа гулгаатай нөхцөлд сав, вагонцистерн, автоцистерн дээр ажиллах (түвшин хэмжих, дээж авах зэрэг) бол аюулгүй байдлыг хангах нэмэлт арга (нэмэлт гэрэлтүүлэг, хальтаргаа арилгах, ажилтны тоог нэмэх, хашилт, хамгаалалтын бүс хэрэглэх зэрэг) хэмжээ авна.

3.1.18. -40°C хэмээс хүйтэн үед гадаа ажиллахыг хориглоно. Орон нутгийн цаг уурын онцлогтой уялдуулан гадаа ажиллахыг хориглох нөхцөлийг агуулахын удирдлага тогтоож болно.

3.1.19. Бүтээгдэхүүн ачих вагонцистернийг салаа замд тавихаас өмнө зохих журмын дагуу үзлэг хийж шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж зөрчлийг арилгах арга хэмжээ авна.

3.1.20. Вагонцистернд ачилт хийхээс өмнө дараах арга хэмжээг авч акт үйлдэнэ. Үүнд:

- вагонцистерний бохирдлын хэмжээг үзлэгээр тодорхойлох
- бүтээгдэхүүний үлдэгдэл байгаа бол хэмжээг тогтоох, төрөл маркийг тодорхойлох
- вагонцистерний люк, таг, жийргийг шалгах
- хүйсний техникийн байдлыг шалгах
- шат, тавцан, бариулын техникийн байдлыг шалгах

3.1.21. Техникийн үзлэг хийж акт үйлдсэний дараа вагонцистернийг ачилтад хүлээн авна. Хүйс, люкийн таг, шат гэмтэлтэй, битүүмжлэл алдагдсан, ломбодох хэрэгсэлгүй вагонцистернд ачилт хийхийг хориглоно.

3.1.22. Ачилтад оруулах вагонцистерн бүрэн бүтэн, тухайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх стандартын шаардлага хангасан байх ёстой. Вагонцистерний бүрэн бүтэн байдлыг хангах асуудлыг гэрээний дагуу төмөр замын байгууллага хариуцна.

3.1.23. Ачилтын явцад вагонцистернээс гоожилт, нэвчилт илэрвэл ачилтыг зогсоож гоожилтийг арилгах бөгөөд боломжгүй бол ачсан бүтээгдэхүүнийг суллана. Вагонцистерний ачиж буулгах төхөөрөмжийн орчинд вагонцистернд засвар хийхийг хориглоно.

3.1.24. Ачих гарын үзүүрийг вагонцистерн доторх шингэний түвшин доор, цистерний ёроолоос 200 мм-ээс илүүгүй зайд байрлуулж, цацруулалгүйгээр ачилтыг хийх бөгөөд температурын тэлэлтийг тооцсон, тогтоогдсон түвшин хүртэл дүүргэнэ. Ачих гар нь вагонцистерний ёроолд хүрхүйц урттай, төгсгөвч нь оч үсэргэдэггүй материалаар хийгдсэн байна. Ачих гаранд цахилгаан дамжуулдаггүй хоолой ашиглах тохиолдолд төгсгөвчийг 2 мм-ийн голчтой зэс утас 4 мм-ын голчтой уян зэс утсаар (троссоор) хийж үзүүрийг шугам хоолойд боолтоор буюу гагнуураар холбож газардуулна.

3.1.25. Ачилтын явцад вагонцистернд өөр зүйл орох, шингэний гадаргуу дээр ямар нэг зүйл хөвж байгаа эсэхэд хяналт тавих шаардлагатай.

3.1.26. Ачилт дууссаны дараагаар ачих хоолойг өргөж бүтээгдэхүүн бүрэн гоожиж дууссаны дараагаар вагонцистернээс гаргана. Түвшинг хэмжсэний дараагаар вагонцистерний люкийг жийрэглэж битүүмжлэн болгоомжтойгоор шидэлгүйгээр хаана.

3.1.27. Вагонцистернээс бүтээгдэхүүн буулгахаас өмнө тээврийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан илгээгчийн ломбоны бүрэн бүтэн байдалд үзлэг хийнэ. Ачааны дагалдах баримт бичиг, чанарын паспортыг холбогдох ажилтнууд шалгасны дараа холбогдох дүрэм журмын дагуу дээж авах, хэмжилт хийх, хувийн жин, температурыг тодорхойлох ажлыг гүйцэтгэнэ.

3.1.28. Хүлээн авах саванд урсгалаар буулгаж байгаа үед хүлээн авах савнаас хадгалах сав руу шилжүүлэн шахах ажиллагааг зэрэг гүйцэтгэнэ. Хүлээн авах савны багтаамж нь нэгэн зэрэг буулгах вагонцистернүүдийн нийлбэр багтаамжийн 75 хувиас багагүй байх ба насосын хүчин чадал хүлээн авах савны дүүргэлтийн зарцуулгын 50 хувиас багагүй байна. Хүлээн авах савнууд халилтаас хамгаалах хэрэгсэлтэй байна.

3.1.29. Ачиж буулгах ажиллагааны хугацаа ашиглагдаж байгаа техник хэрэгслийн үзүүлэлт, бүтээгдэхүүний шинж чанар, цаг агаарын нөхцөлөөс хамаарна.

3.1.30. Вагонцистернийг ачиж буулгах төхөөрөмжийн замд татахаас өмнө зам болон орчинг шалгаж бүтээгдэхүүн асгарсан байвал цэвэрлэж аюулгүй болгоно.

3.1.31. Байгууламжийн бүсэд вагонцистерний ивүүр ашиглахад оч үсрэхээс сэргийлэх хэрэгтэй.

3.1.32. Вагонцистерний люкийг нээх хаахдаа цохилгүйгээр болгоомжтой ажиллана.

3.1.33. Вагонцистернийг ямар ч зориулалтаар хөдөлгөхөөс өмнө түүний хөдөлгөөнд бэлэн эсэхийг сайтар шалгаж үйл ажиллагааг удирдах албан тушаалтнаас зөвшөөрөл авна.

3.1.34. Бүтээгдэхүүн тээвэрлэж ирсэн вагонцистерний хүйс гэмтэлтэй тохиолдолд төмөр замын байгууллагад мэдэгдэж буулгах хугацааг сунгах зөвшөөрөл авна. Вагонцистерний хүйс гэмтэлтэй буюу бүтээгдэхүүнд тохирохгүй вагонцистерн ирсэн тохиолдолд бүрт төмөр замын байгууллагын төлөөлөгчтэй хамтарсан акт үйлдэнэ.

3.1.35. Вагонцистерний хүйс гэмтэлтэй үед зориулалтын бус багажаар онгойлгохыг хориглоно. Энэ тохиолдолд тухайн вагонцистернийг дээд люкээр буулгана.

3.1.36. Зунгалаг багатай, хялбар асах бүтээгдэхүүнийг вагонцистернээс дээгүүр буулгахад вакуум систем ашиглана.

3.1.37. Ачих буулгах үйл ажиллагаа явагдаагүй үед вагонцистернийг ачиж буулгах хэрэгслээс салгасан байна.

3.1.38. Ачиж буулгах үйл ажиллагааны үед ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажиллагсдаас бусад хүмүүсийг тухайн бүсэд байхыг хориглоно.

3.1.39. Байгууламж байрласан зам дээр толгойг зогсоох, нэвт өнгөрүүлэхийг хориглоно.

3.1.40. Ачиж буулгах байгууламжийн коллектороор өөр өөр төрлийн бүтээгдэхүүн ээлжлэн ачих, буулгах тохиолдолд коллекторыг бүтээгдэхүүнээс бүрэн сулласан байх ёстой. Зунгалаг ихтэй бүтээгдэхүүн болон тунгалаг бүтээгдэхүүнд нэг коллектор ашиглахын хориглоно.

3.1.41. Ачих буулгах хэрэгслийг удирдлагагүйгээр хөдлөхөөс сэргийлж хөдөлгөх механизмд түгжээ хийнэ.

3.1.42. Ачих буулгах байгууламжид засвар хийх үед оч үсрэхээс хамгаалсан багаж ашиглана.

3.1.43. Вагонцистернийг байрлалд тохируулж хөдөлгөхөд зөвхөн зориулалтын төхөөрөмж ашиглана.

3.1.44. Зунгалаг өндөртэй бүтээгдэхүүнийг дулаалгагүй вагонцистернээр тээвэрлэсэн тохиолдолд буулгахын тулд зориулалтын төхөөрөмж ашиглан халааж болно. Энэ зорилгоор задгай гал буюу түүнтэй адил төхөөрөмж ашиглахыг хориглоно.

3.1.45. Ууран болон цахилгаан халаагуур ашиглах тохиолдолд халаагуурыг шингэнд дүрсний дараа ажиллуулна. Цахилгаан халаагуураар 120°C хэмээс доош дүрсхийх температур бүхий бүтээгдэхүүн халаахыг хориглоно.

3.1.46. Бүтээгдэхүүнийг халаах температур дүрсхийх температураас 35°C хэмээс доогуур, гэхдээ 90°C хэмээс илүүгүй байх ёстой. Халааж байх үед бүтээгдэхүүний температурыг хянаж бүртгэл хөтөлнө.

3.1.47. Цахилгаан халаагуурыг ашиглахдаа галын болон цахилгаан хангагч байгууллагаас зөвшөөрөл авна.

3.1.48. Халааж байх үед температурын өсөлтөөс шалтгаалан бүтээгдэхүүн вагонцистернээс хальж асгарахаас сэргийлж хянаж байх ёстой.

Автоцистернд ачих буулгах

3.1.49. Бүтээгдэхүүнийг автоцистернд ачих буулгах ажиллагааг холбогдох стандарт, норм дүрмийн шаардлагын хүрээнд зураг төслийн дагуу байгуулсан автоцистерний ачих байгууламжид гүйцэтгэнэ. Буулгах, ачих үйл ажиллагааны горим нь ачих буулгах тоног төхөөрөмжийн төрөл, хүчин чадал, автоцистерний буулгах болон ачих хэрэгслийн төрөл, бүтээгдэхүүний шинж чанар, цаг агаарын нөхцөл зэргээс хамаарна. Агуулахын удирдлага өөрийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний төрөл, нөлөөлж болох бусад хүчин зүйлүүдийг үндэслэн энэхүү дүрэм бусад холбогдох дүрэм заавруудын дагуу ачих буулгах технологийн горимыг баталж мөрдүүлнэ.

3.1.50. Ачих байгууламжид ачих гар (loading arm), шат тавцан, удирдлагын байр, технологийн хоолой, ачих талбай болон шингэний тоолуур, насос зэрэг бусад тоног төхөөрөмжүүд байна.

3.1.51. Автоцистернд ачих төхөөрөмжийг хамгаалах, үйл ажиллагааг явуулах нөхцөлийг хангах, бүтээгдэхүүнд хурын ус орох, хурын усыг бохирдлоос хамгаалах үүднээс ачих байгууламж саравчтай байх нь зүйтэй.

3.1.52. Ачих байгууламжийн бүх тоног төхөөрөмж, байгууламжийн бүрэн бүтэн байдалд холбогдох ажилтан хяналт тавих ба эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засварлах шаардлагатай. Эвдрэл гэмтэлтэй үед ачилт хийхийг хориглоно.

3.1.53. Автоцистерн, ачих гарын төрөл, хийцээс хамаарч автоцистерний дээд люкээр эсхүл торхны доор байрласан зориулалтын ачих хэрэгслээр ачиж болно. Нисэхийн шатахууныг автоцэнэглэгчид ачихад зөвхөн доороос ачих төхөөрөмж ашиглана.

3.1.54. Автоцистернд ачиж байгаа бүтээгдэхүүний хэмжээг шингэний тоолуур ашиглах, торхны баталгаажсан багтаамжаар тооцох, автоцистернийг жинэлэх аргуудаар тодорхойлно.

3.1.55. Автоцистернд ачих гар, буулгах байр, технологийн тоног төхөөрөмж, хаалтууд агуулахын технологийн схемийн дагуу дугаарлагдсан байна.

3.1.56. Тухайн тоног төхөөрөмжийн талаар сургалтад хамрагдаж мэргэшсэн ажилтан ачих системийг ажиллуулна.

3.1.57. Ачих гарын үзүүрийн хоолойг (автоцистерний торхонд дүрэгдэх хэсэг) оч үсэргэдэггүй материалаар хийсэн байна. Хэрэв уян хоолойг ачих гарын зориулалтаар (шланг) ашиглаж байгаа бол үзүүрт нь оч үсэргэдэггүй материалаар хийсэн төгсгөвч хийж газардуулгад холбоно.

3.1.58. Ачих гар төгсгөвчөөсөө шугам хоолойн холболт хүртэл тасралтгүй цахилгаан хэлхээ үүсгэж газардуулагдсан байх ёстой. Шарнир холбоотой хоолойнуудаас бүрдсэн төхөөрөмжийн шарнирийн жийрэг цахилгаан хэлхээг тасалж болох тул байнга шалгаж байх нь зүйтэй.

3.1.59. Ачилтын насосыг аваарын үед унтраах хэрэгслийг хүрэхэд хялбар газар байрлуулна.

3.1.60. Ачилт буулгалт эхлэхээс өмнө автоцистернийг газардуулгад холбох ба газардуулга салсан үед үйл ажиллагааг зогсоох хэрэгслээр тоноглоно.

3.1.61. Доогуур ачих, буулгах төхөөрөмжийн цистернд холбох хэрэгсэл оч үсэргэхгүй металаар хийгдсэн, цистерний холбох хэрэгсэлд таарч битүүмжлэл хангаж найдвартай холболт үүсгэдэг, холболт салахад автоматаар хаагддаг байх ёстой. Ачилт, буулгалт хийхэд төхөөрөмжийг холбосны дараа холболтыг нарийвчлан шалгасны дараа ажиллагааг эхэлнэ.

3.1.62. Ачих гарын үзүүрийг автоцистерн доторх шингэний түвшин доор, торхны ёроолоос 200 мм-ээс илүүгүй зайд байрлуулж, цацруулалгүйгээр ачилтыг хийнэ.

3.1.63. Ачилтын явцад автоцистернээс гоожилт, нэвчилт илэрвэл ачилтыг зогсоож гоожилтийг арилгах бөгөөд боломжгүй боломжгүй бол автоцистернийг ачих байгууламжаас зайлуулж холбогдох арга хэмжээ авна.

3.1.64. Ачилт дууссаны дараагаар ачих гарын үзүүрийг өргөж бүтээгдэхүүн бүрэн гоожиж дууссаны дараагаар торхноос бүрэн гаргана. Ачих гараас үлдэгдэл бүтээгдэхүүн дусахгүй байх арга хэмжээ авсан байна.

3.1.65. Ачих төхөөрөмжийг зөв ашиглах талаар жолоочид газар дээр нь зааварчилга өгнө.

3.1.66. Хялбар асах бүтээгдэхүүн ачих тээврийн хэрэгслийн жолооч цэнэгжидэг материалаар хийсэн хувцастай байхыг хориглоно.

3.1.67. Ачилт хийлгэх автоцистерн холбогдох дүрэм журмын шаардлага хангасан, ачаа авахад бэлтгэгдсэн байна.

3.1.68. Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, яндангийн оч баригч зэргийг ачих, буулгах ажиллагаа эхлэхээс өмнө шалгана. Шаардлага хангаагүй автоцистернийг ачилтад оруулахыг хориглоно.

3.1.69. Автоцистернийг ачиж байх үед хөдөлгүүр унтраатай байна. Агаарын температур хасах байгаа үед хөдөлгүүр асаахыг зөвшөөрнө.

3.1.70. Ачих буулгах байгууламжид бүтээгдэхүүн асгарсан тохиолдолд бүрэн цэвэрлэж аюулгүй болтол тээврийн хэрэгслийн хөдөлгүүр асаахыг хориглоно.

3.1.71. Ачих буулгах төхөөрөмжийг салгаагүй байх болон дээр нь хүмүүс ажиллаж байх үед автоцистерн хөдлөхөөс сэргийлэх хэрэгсэл (гэрэл, дохио, хаалт, ивүүр г.м) ашиглах нь зүйтэй.

3.1.72. Аянга цахилгаантай үед ачилт хийхийг хориглоно.

3.1.73. Ачих буулгах хэрэгслийг удирдлагагүйгээр хөдлөхөөс сэргийлж хөдөлгөх механизмд түгжээ хийнэ.

3.2. Бүтээгдэхүүнийг хадгалах

3.2.1. Бүтээгдэхүүнийг саванд хадгалах үйл ажиллагааг холбогдох стандарт заавар журмын дагуу гүйцэтгэнэ. Бүтээгдэхүүний хадгалалтын үеийн алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах зорилгоор бүтээгдэхүүний шинж чанар, ашиглалтын нөхцөлтэй уялдуулан техник-эдийн засгийн тооцоо хийсний үндсэн дээр хадгалах савны төрлийг сонгоно.

3.2.2. Сав, савны тоног төхөөрөмжүүд холбогдох стандартын шаардлагыг хангасан, хадгалах бүтээгдэхүүний шинж чанар, орчны нөхцөлд тохирсон байна. Мөстөлтөөс хамгаалах шингэнийг дотор талд бүрхүүл тавиагүй, цайрдаагүй ган саванд (зэвэрдэггүй ган сав илүү үр дүнтэй) хадгалах ба хөнгөн цагаан болон хайлшаар хийсэн саванд хадгалахыг хориглоно.

3.2.3. Бүтээгдэхүүн тус бүрийг тусгай, зориулалтын саванд хадгална.

3.2.4. Нисэхийн түлшийг хөвдөг дээвэртэй саванд хадгалахыг хориглох ба зарлагын савыг бүтээгдэхүүний дээд түвшингээс зарлага гаргах зориулалтын хэрэгслээр тоноглоно.

3.2.5. Савны ашиглалтын үед дараах чиглэлээр онцгой анхаарал тавих шаардлагатай. Үүнд:

- савны битүүмжлэлийг хангах
- хана ёроолын зузааныг хянах
- савны геометр хэмжээний өөрчлөлт, хазайлт
- тоног төхөөрөмжийн ажиллагаа
- аянгаас хамгаалах төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал
- статик цэнэгжилтээс хамгаалах ажиллагаа

3.2.6. Хадгалалтын үед бүтээгдэхүүний ууршилтаас гарах алдагдлыг багасгахын тулд дараах арга хэмжээ авна. Үүнд:

- хөвөгч таг, хөвүүртэй сав ашиглах,
- савны дээврийн битүүмжлэлийг бүрэн хангах,
- саванд тогтоосон даралттай байлгах,

- ууршимтгай бүтээгдэхүүнийг савнаас сав руу шилжүүлэх ажиллагааг аль болох хийхгүй байх, гарцаагүй шаардлагатай тохиолдолд ууршилт бага гардаг цагаар гүйцэтгэх,
- ууршимтгай бүтээгдэхүүнийг саванд аль болох дүүрэн хадгалах,
- савны гадна талыг гэрэл ойлгох цайвар өнгөөр будах,
- савыг дулаан тусгаарлах бүрхүүлээр бүрэх,

3.2.7. Давхар ханатай босоо сав (tank in tank) ашиглаж байгаа тохиолдолд хана хоорондын орон зайд бүтээгдэхүүний алдагдал, тэсрэлтийн аюултай хийн хуримтлалд хяналт тавина.

3.2.8. Ууршилтын алдагдлыг багасгах зорилгоор бензин хадгалах зориулалтаар хөвдөг дээвэр, хөвүүр, бусад төрлийн бүрхүүл бүхий савнуудыг ашиглах буюу хийн холболтыг ашиглаж болно.

3.2.9. Амьсгалын клапан тавьсан тохиолдолд адил хүчин чадлын хамгаалах клапан тавих ба тэдгээрийг тусдаа хоолой дээр суурилуулна.

3.2.10. Саван доторх даралтыг амьсгалын болон хамгаалах клапангийн ажиллагаагаар зохицуулна. Амьсгалын клапан хөлддөггүй хийцтэй, хэрэв гидравлик хамгаалах клапан ашиглаж байгаа бол хөлддөггүй, царцдаггүй, өтгөрдөггүй, хялбар ууршдаггүй шингэн ашиглана.

3.2.11. Савны орлого зарлагын дээд зарцуулга амьсгалах, хамгаалах хэрэгслийн үзүүлэлтээс хэтэрч болохгүй.

3.2.12. Хөвдөг дээвэртэй буюу металл хөвүүртэй саванд орлого зарлага хийх үед дээвэр, хөвүүрийн өргөгдөх буух хурд 700 м3 хүртэл багтаамжийн саванд-3,3 м/цаг, 700 м3 –аас дээш багтаамжийн саванд -6 м/цаг-аас хэтрэхгүй, хэвтээ чиглэлд эргэх хурд 700 м3 хүртэл багтаамжийн саванд-2,5 м/цаг-аас илүүгүй байх ёстой. Металлаас бусад материалаар хийсэн хөвүүрийн өргөх хурдны хязгаарыг техникийн баримт бичигт заасан дагуу тодорхойлно.

3.2.13. Бүтээгдэхүүний доор байх усны түвшин тухайн савнаас усыг шавхаж болох хамгийн бага хэмжээнд байх ёстой. Өвлийн цагт сифон краны үзүүрийг хажуу тал руу эргүүлэн байрлуулна.

3.2.14. Царцамтгай бүтээгдэхүүнийг дулаалгатай, бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүй, галын аюулгүйн шаардлага хангасан халаах хэрэгсэл бүхий саванд хадгална. Халаах хэрэгслийг техникийн баримт бичиг, зааврын дагуу суурилуулж ашиглана.

3.2.15. Саванд хадгалах бүтээгдэхүүний төрлийг солих нөхцөлд холбогдох дүрэм журмын дагуу савыг бэлтгэнэ.

3.2.16. Савны паркын хог хаягдал, хатсан өвсийг байнга цэвэрлэж байна. Бүтээгдэхүүн асгарсан тохиолдолд зохих журмын дагуу цэвэрлэж аюулгүй болгоно. Сав паркт шатдаг материал хадгалахыг хориглоно.

3.2.17. Жижиглэн савласан бүтээгдэхүүнийг тусгайлан төхөөрөмжилсөн галын аюулгүйн шаардлага хангасан байр, саравч, задгай талбайд хадгална. Хадгалах байрыг цаг уурын нөхцөл, бүтээгдэхүүний шинж чанар, сав баглаа боодлоос хамааруулж сонгоно.. Бүтээгдэхүүний сав, баглаа боодол нь холбогдох стандартын шаардлага хангах ёстой.

3.2.18. Үл хөлдөх шингэн, нисэх онгоцны гидрийн шингэн болон 450С болон бага дүрсхийх температур бүхий хялбар асах бүтээгдэхүүнийг гадаа хадгалахыг хориглоно.

3.2.19. Хялбар асах шингэнийг тэдгээртэй холилдоход тэсрэлтийн аюул үүсгэх шинж чанартай бүтээгдэхүүнийг хамт нэг өрөөнд хадгалахыг хориглоно.

3.2.20. Ашиглалтанд байсан, бүтээгдэхүүнээр бохирдсон сав, баглаа боодлыг задгай талбайд хадгална.

3.3. Бүтээгдэхүүний чанар, чанарын хяналт

3.3.1. Хэрэглэгчид чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн олгох, чанарын баталгаажуулалт хийх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор бэлтгэл

ажлын үед болон агуулахын технологийн үйл ажиллагааны явцад бүтээгдэхүүний чанарыг хадгалах, чанарт хяналт тавих чиглэлийн цогц арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай.

3.3.2. Бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, олгох үед чанарыг хадгалах, чанарт хяналт тавих арга хэмжээг MNS 4633:2006 “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачлал” стандарт болон бусад холбогдох норм, дүрэм журмын дагуу агуулахын удирдлага зохион байгуулна.

3.3.3. Агуулахад хүлээн авч байгаа болон агуулахаас олгож байгаа бүтээгдэхүүнд чанарын паспорт дагалдах ёстой. Чанарын паспортод холбогдох норм, дүрмийн дагуу бүтээгдэхүүний шаардлагатай үзүүлэлтүүд бичигдэх ба агуулахаас олгож байгаа болон хүлээн авч байгаа багц бүрийг дагалдана.

3.3.4. Хүлээн авах үед бүтээгдэхүүний стандартын үзүүлэлт болон нийлүүлэлтийн тусгай нөхцөлийн дагуу бүтээгдэхүүний чанарыг шалгана. Бүтээгдэхүүний чанар, үзүүлэлтүүд ачаа тээврийн дагалдах баримт бичигт заасан стандартаас зөрсөн тохиолдолд хүлээн авах ажиллагааг зогсоож акт үйлдэнэ.

3.3.5. Бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, олгох үед хийгдэх шинжилгээнд хэрэглэгдэх багаж хэрэгсэл агуулахын лабораторид байх ёстой. Хэрэв шаардлагатай техник хэрэгслээр хангагдаагүй бол эрх бүхий өөр байгууллагаар шинжилгээ хийлгэхийг зөвшөөрнө.

3.3.6. Бүтээгдэхүүнд холилдсон усыг ялгах ажиллагааг холбогдох технологийн дагуу зориулалтын тоног төхөөрөмж дээр гүйцэтгэнэ.

3.4. Агуулахын хэмжил, баталгаажуулалт

3.4.1. Агуулахад бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, олгох үйл ажиллагаа, чанарын баталгаажуулалт хийх үед хэмжүүрийн нэгдмэл байдал, хэмжлийн нарийвчлалыг хангах, холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн техник зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай. Агуулахын хэмжил, баталгаажуулалтын гол үүрэг нь:

- бүтээгдэхүүний хэмжээ, чанарын талаарх хэмжлийн үнэн зөв мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх
- улсын баталгаажилтад хамрагдах хэмжүүрүүдийн шалгалтын ажлыг зохион байгуулах
- хэмжүүрийн тохиргоо хийх
- ашиглалтад байгаа хэмжүүрүүдийн засвар үйлчилгээг зохион байгуулах
- хэмжилзүйн шинэ техник, технологи нэвтрүүлэх

3.4.2. Хэмжүүр, хэмжих аргад дараах үндсэн шаардлага тавина:

- худалдааны тооцоонд ашиглаж байгаа хэмжүүрүүдийн нарийвчлал холбогдох стандартын шаардлагыг хангаж байна,
- бүтээгдэхүүний худалдаа, чанарын баталгаа, улсын хяналт, хүрээлэн байгаа орчны хяналт, хөдөлмөр хамгааллын зорилгоор ашиглагдаж байгаа хэмжих хэрэгслийг холбогдох хууль дүрэм журмын дагуу туршилт, шалгалтад хамрагдана,
- шаардлагатай хэмжүүрүүдийг орон нутгийн хэмжүүрийн байгууллага шалгаж баталгаажуулна,
- улсын хяналтад хамрагдаагүй хэмжих хэрэгслийг байгууллагын хяналтад хамруулна,

3.4.3. Савны багтаамж, хадгалж байгаа бүтээгдэхүүний эзэлхүүнийг тодорхойлох боломжийг хангасан, холбогдох стандарт, зааврын дагуу зохиосон онооллын хүснэгттэй байна. Савыг шинээр барих, их засвар хийх, геометр хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд онооллын хүснэгтийг зохионо.

3.4.4. Агуулахын технологийн хоолойн багтаамжийг бүтээгдэхүүн, хэсгүүдээр ангилж тогтоосон байна.

Дөрөв. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Сав парк

4.1.1. Агуулахын бүтээгдэхүүн хадгалах сав холбогдох стандартын шаардлага хангасан байх бөгөөд, шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

4.1.2. Савыг ашиглалтанд хүлээн авах, ашиглах, засварлах ажиллагааг холбогдох дүрмийн дагуу зохион байгуулна.

4.1.3. Савыг зураг төслийн дагуу угсарна. Савны суурь ёроолоор бүтээгдэхүүн алдаж байгаа эсэхийг хянах боломжтой хийцтэй байна.

4.1.4. Савыг технологийн схемд заасны дагуу дугаарласан байх бөгөөд сав бүрт холбогдох журмын дагуу паспорт хөтөлнө. Сав бүрийн хэмжих люкийн дээд ирмэгээс харалдаа ёроол хүртэлх зайг тогтоож жил бүр шалгана.

4.1.5. Савны хөвүүрийг техникийн баримт бичиг, ашиглалтын зааврын дагуу зохион ашиглана.

4.1.6. Савны тоноглолууд битүүмжлэл хангасан, зориулалтын жийрэгтэй байна.

4.1.7. Савны суулт, хэв гажилт, суурийн хазайлт зэрэг үзүүлэлтүүд холбогдох нормын заалтын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрч болохгүй. Шинээр барьсан савны суултыг ашиглалтын эхний 5 жилд жил тутам холбогдох зааврын дагуу шалгаж бүртгэж байна.

4.1.8. Сав паркийн далан буюу хязгаарлах хана холбогдох нормын шаардлагыг хангаж байна. Далангийн дотор засварын ажил гүйцэтгэхэд техник оруулах зорилгоор даланг сэтгэхийг зөвшөөрнө. Энэ тохиолдолд засварын ажлыг дуусч, даланг хэвийн байдалд оруултал тухайн далан дотор байрласан саванд бүтээгдэхүүн дүүргэхийг хориглоно. Гал хэрэглэсэн ажил гүйцэтгэх тохиолдолд галын аюулгүй шаардлагыг бүрэн хангаж ажиллана.

4.1.9. Савны орлого зарлагын хаалтууд гар удирдлагатай байна. “А” ангиллын агуулахад савны орлого зарлагын хаалтаас гадна түүний үүргийг гүйцэтгэх зориулалттай удирдлагатай хаалтыг далангийн гадна нэмж тавих ба удирдлагыг операторын байранд байрлуулна.

4.1.10. Савны засвар хийхэд ажил гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулж агуулахын удирдлага баталсан байна.

4.1.11. Засварын ажлыг эхлэхээс өмнө савыг суллах, цэвэрлэх, агааржуулах, саван доторх хийн найрлагад тэсрэлтийн аюулгүйн шинжилгээ хийх, ажил гүйцэтгэх хүмүүст зааварчилгаа өгөх, багаж хэрэгсэл бэлтгэх зэрэг бэлтгэл ажлуудыг гүйцэтгэнэ.

4.1.12. Галын аюулгүйн болон хөдөлмөр хамгааллын дүрмүүдийн шаардлагыг ягштал биелүүлж тухайн нөхцөл байдалд тохирсон шаардлагатай бүх арга хэмжээг авна. Бэлтгэл ажлыг бүрэн бэлэн болсны дараагаар хариуцсан удирдах ажилтан бэлтгэлийг нягтлан шалгаж ажил эхлэх зөвшөөрлийг бичгээр олгоно.

4.1.13. Засварын ажил дууссаны дараагаар хийгдсэн ажлын арга технологи, хэрэглэсэн материалын сертификат, далдлагдсан ажлын акт, гагнуурын оёдлын шалгалтын акт бусад шаардлагатай баримт бичгийг бүрдүүлсэн байна.

4.1.14. Савны ёроолын гагнуурын оёдлыг тусгай төхөөрөмжөөр шалгах ба бусад оёдлыг керосиноор шалгахыг зөвшөөрнө. Шалгалтаар илэрсэн согогийг засварлаж дахин шалгана.

4.1.15. Засварын ажил, баримт бичгийг шалгасны дараагаар шаардлагатай туршилтыг холбогдох зааврын дагуу хийнэ.

4.1.16. Савны тоног төхөөрөмжид ашиглалтын зааврын дагуу буюу дараах үечлэлээр техникийн үзлэг хийж бүртгэлд тэмдэглэнэ. Үүнд:

– амьсгалын клапан, шингэний хамгаалах клапан – дулааны улиралд сард 2-оос доошгүй, хүйтний улиралд 10 хоног тутам,

- гал хамгаалагч - дулааны улиралд сар тутам, хүйтний улиралд 10 хоног тутам,
- агааржуулах хоолой – сар бүр,
- хөөсний генератор, хөөсний камер - сар бүр,
- түвшин хэмжигч, дээж авагч, түвшин хязгаарлагч хэрэгслүүд - сар бүр,
- орлого зарлагын хоолой, хаалт, сифон кран – ашиглах бүрт, гэхдээ сард 2-оос доошгүй удаа,

4.1.17. Амьсгалын клапаны ажиллагааг хэвийн байлгахын тулд хүйтний улиралд цанталтаас тогтмол цэвэрлэж байна. Цэвэрлэх үечлэл нь цанталтын хэмжээ, цаг агаарын нөхцөлөөс хамаарна.

4.1.18. Амьсгалын хэрэгслийн хүчин чадлыг нь орлого зарлагын дээд зарцуулга, хийн температурын тэлэлтээс хамааруулан тооцож тогтооно.

4.1.19. Савыг хүйтний улиралд ашиглалтад бэлтгэх ажлын хүрээнд усыг шавхах, амьсгалын болон хамгаалах клапан, дээж авагч, түвшин хэмжигч хэрэгслүүдийг шалгах, бэлтгэх арга хэмжээг авна. Сифон краныг цэвэрлээд богино хоолойг эргүүлж хажуу байрлалд үлдээнэ.

4.1.20. Онгоцны түлш, онгоцны тосолгооны материал хадгалах савыг жилд 2-оос доошгүй, бусад бензин, дизелийн түлш, тос бусад төстэй шинж чанар бүхий бүтээгдэхүүн хадгалах савыг жилд 1-ээс доошгүй удаа цэвэрлэнэ. Бусад төрлийн бүтээгдэхүүн хадгалах савыг бүтээгдэхүүний чанар, савны ашиглалтын шаардлагыг үндэслэн тухай бүр цэвэрлэнэ. Мөн хадгалж байгаа бүтээгдэхүүний төрөл солих, ус тунадсыг цэвэрлэх, саванд засвар, оношилгоо хийх үед савыг цэвэрлэнэ. Бүтээгдэхүүнийг удаан хугацаагаар хадгалах тохиолдолд савыг суларсны дараа цэвэрлэхийг зөвшөөрнө. Саванд засвар хийх, хадгалж байснаас илүү чанарын бүтээгдэхүүн хадгалах тохиолдолд саванд цэвэрлэгээ хийнэ.

4.1.21. Агуулахад сав цэвэрлэх хуваарь, цэвэрлэгээг хийх заавар журам, гаргаж удирдлага баталсан байна.

4.1.22. Хүхэр агуулсан бүтээгдэхүүн хадгалж байсан саванд цэвэрлэгээ хийх үед хүхэрт нэгдлүүд өөрөө шатахаас сэргийлэх зорилгоор зэврэлтээс үүссэн тунадсыг савнаас гаргатай чийгтэй байлгана.

4.1.23. Сав цэвэрлэсний дараа холбогдох маягтын дагуу акт үйлдэнэ.

4.1.24. Савыг шавхах ажиллагааг галын аюулгүйн шаардлага хангасан тусгай төхөөрөмж ашиглан гүйцэтгэнэ.

4.1.25. Саванд дахь аюултай хийн холимгийг аюулгүй түвшинд хүртэл гаргах ажиллагааг савыг тусгай уусмалаар угаах буюу угаасны дараа агааржуулах замаар гүйцэтгэнэ. Агааржуулалт хийхэд савны бүх люкийг нээх ба цахилгаан төхөөрөмж ашиглах бол саванд чичиргээ өгөхгүй, оч үсэргэхгүй байхаар суурилуулна.

4.1.26. Цэвэрлэх зорилгоос хамаарч саван доторх агаар дахь бүтээгдэхүүний уурын агууламж доор зааснаас илүүгүй байна. Үүнд:

- бензин хадгалж байсан сав дотор хүмүүс ажиллаж гал хэрэглэсэн засварын ажил хийх, хамгаалалтын баг ашиглахгүйгээр бусад ажил гүйцэтгэх – 0,1 г/м³,
- сав дотор хүн ажиллахгүйгээр гал хэрэглэсэн ажил гүйцэтгэх - 0,2 г/м³,
- тунгалаг бүтээгдэхүүний саванд хамгаалах хэрэгсэл ашиглаж гал хэрэглэхгүй ажил гүйцэтгэх - 8,0 г/м³,

Саван дотор хүмүүс ажил гүйцэтгэж байх үед сорох агааржуулалтын төхөөрөмж ашиглах нь зүйтэй.

4.1.27. Саван дотор гүйцэтгэх ажлыг тухайн ажлыг удирдахаар томилогдсон ажилтны байнгын хяналт дор гүйцэтгэх бөгөөд ажил эхлэх зөвшөөрлийг удирдлагаас бичгээр авсан байна. Агаарын шинжилгээний бичгийг ажил эхлэх зөвшөөрөл хавсаргана.

4.1.28. Саванд зэврэлтээс хамгаалах бүрхүүл түрхэх ажлыг тусгай зааврын дагуу хийнэ. Дотор талд түрхэх түрхлэг бүтээгдэхүүнд тэсвэртэй, бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүй байх ёстой.

4.1.29. Ашиглалтанд байгаа савны техникийн байдлыг тодорхойлохын тулд заасан хугацаанд холбогдох дүрэм журмын дагуу оношилгоо хийнэ. Оношилгоогоор савны

техникийн байдал, ашиглалын нөөцийг тогтоож цаашид ашиглах нөхцөлийг зааж дүгнэлт гаргана.

4.1.30. Саванд үзлэг хийхэд доод бүслүүр, ёроол ханын холбоос гагнуурын оёдолд онцгой анхаарал хандуулах шаардлагатай.

4.1.31. Савны суурийг хурын ус гэмтээхээс хамгаалж ус зайлуулах арга хэмжээ авна.

4.1.32. Савны ёроолын ирмэгийг байнга цэвэрлэж ус, цас тогтохоос сэргийлнэ.

4.1.33. Аюул ослын үед сав дахь бүтээгдэхүүнийг өөр сав руу шилжүүлж болох нөхцөлийг хангаж байхаар тооцож технологийн хоолойн холболтыг төлөвлөнө.

4.1.34. Хөвдөг дээвэр, хөвүүрийн битүүмжлэх хэрэгслийн материал бүтээгдэхүүний шинж чанарт тохирсон байна.

4.1.35. Савласан бүтээгдэхүүнийг хадгалах байгууламжийг холбогдох норм дүрмийн хүрээнд зураг төслийн дагуу байгуулна.

4.1.36. Савласан бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын байр нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

- тээврийн хэрэгслийн очих замтай байх,
- төмөр замаас савласан бүтээгдэхүүн буулгах тавцан байх,
- агааржуулах систем нь цагт 2-3 удаа агаар сэлгэх хүчин чадалтай байх,
- агаарын аюултай холимог үүсэхэд мэдээлэх хэрэгслээр тоноглогдсон
- хоёроос доошгүй хаалгатай байх,
- шал нь асгарсан бүтээгдэхүүнийг урсгах зориулалтын налуутай, цуглуулах сувагтай,
- ачих буулгах ажиллагааг механикжуулах хэрэгсэл,
- савласан бүтээгдэхүүн хураах тавиур вандантай байх,

4.2. Технологийн хоолой

4.2.1. Агуулахад бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, олгох, сав сэлгэх, сав суллах зэрэг үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэх, байгууламжууд, технологийн тоног төхөөрөмжүүдийн хооронд бүтээгдэхүүнийг дамжуулах зориулалтаар технологийн хоолойг ашиглана. Технологийн хоолойн бүрэлдэхүүнд хаалт, хамгаалах, тохируулах, хэмжих, хянах хэрэгсэл, шүүлтүүр, хий авагч, компенсатор зэрэг холбогдох хэрэгслүүд багтана.

4.2.2. Агуулахад бүх хоолой, сав, ачих буулгах төхөөрөмж, насос, хаалт, хамгаалах, тохируулах, хэмжих, хянах хэрэгсэл, шүүлтүүр, хий авагч, компенсатор, зэрэг технологийн үйл ажиллагаанд хамаарах тоног төхөөрөмжүүдийг бүрэн тусгасан, тэдгээрийг ялгаж дугаарласан технологийн схем байх ёстой.

4.2.3. Технологийн тоног төхөөрөмжид өөрчлөлт хийх тохиолдолд технологийн схемд тодотгол хийж холбогдох ажилтнуудад танилцуулсан байна. Технологийн схемд өөрчлөлт оруулахад агуулахын удирдлагаас зөвшөөрөл авна.

4.2.4. Төрөл бүрийн бүтээгдэхүүнийг технологийн хоолойгоор дамжуулах ажиллагаа тухайн бүтээгдэхүүний шинж чанараас хамаарах бөгөөд аюулгүй ажиллагааны шаардлагуудад нийцэж байна.

4.2.5. Шингэний цохилт үүсэж хоолой, тоног төхөөрөмжийг эвдэж гэмтээхээс сэргийлэх зорилгоор хаалтыг аажмаар нээж хаах ёстой.

4.2.6. Технологийн хоолойн худгуудын тагийг хаалттай байлгах ба нээж хаахад оч үсрэхээс сэргийлнэ.

4.2.7. Технологийн хоолойг холбогдох норм дүрмийн шаардлагын хүрээнд зураг төслийн дагуу байгуулна. Хоолойн материалыг бүтээгдэхүүний шинж чанар, даралт, орчны нөхцөлөөс шалтгаалан сонгоно. Технологийн хоолойг газар дээр буюу газар доор угсарч болно.

4.2.8. Нисэхийн шатахуун дамжуулах хоолойг бага нүүрстөрөгчит гангаар хийсэн, үйлдвэрийн нөхцөлд тавьсан зэврэлтээс хамгаалах дотор бүрхүүлтэй хоолойгоор хийх ба

зэс, кадмийн хайлш, цайрдсан ган хоолой ашиглахыг хориглоно. Мөстөлтөөс хамгаалах шингэнийг дамжуулах хоолойг зэвэрдэггүй гангаар хийсэн байна.

4.2.9. Температурын өөрчлөлтөөс шалтгаалах деформацийг тооцоолж компенсаторуудыг шаардлагатай газруудад тавина.

4.2.10. Орчны нөлөөнөөс халалт үүсэх нөхцөлд технологийн хоолойд даралтын хамгаалах клапан тавих бөгөөд түүнээс гарах шингэнийг тусгай системээр дамжуулан саванд юүлэх бололцоо хангана.

4.2.11. Газар доорх технологийн хоолойг гагнуураар холбоно. Фланцан холболт, хэрэгслүүдийг газар худагт байрлуулна. Технологийн хоолойг барилга доогуур байрлуулахыг хориглоно.

4.2.12. Технологийн хоолойд ашиглагддаггүй (мухар хэсэг, бүтээгдэхүүн зогсонги байдалтай байдаг) хэсгүүд байж болохгүй.

4.2.13. Хамгийн нам байрласан газруудад юүлэгч байрлуулж цуглуулах системд холбоно.

4.2.14. Технологийн хоолойг юүлэх бололцоог хангаж тухайн нөхцөл, бүтээгдэхүүний шинж чанартай уялдуулан бензин, дизелийн түлш болон бусад төстэй бүтээгдэхүүний хоолойд 0,2 хувиас багагүй, зунгалаг өндөр, царцамтгай бүтээгдэхүүний хоолойд – 2 хувиас багагүй налуутайгаар тавина.

4.2.15. Технологийн хоолойг үлээлгэхэд зориулан эхлэл, төгсгөлийн хэсгүүдэд хаалт, таглагч бүхий богино хоолойнуудыг тавина.

4.2.16. Технологийн хоолойн хаах, тохируулах, хамгаалах хэрэгслүүдийг /арматур/ тэдгээрийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд хялбар газар байрлуулна.

4.2.17. Технологийн хоолойн хэрэгслүүд бүтээгдэхүүний шинж чанар, даралт, температур, ажлын горим, ашиглалтын нөхцөлд тохирсон байна.

4.2.18. Хаалтуудын зангилааг сав паркын гадна талд байрлуулна.

4.2.19. Хааж нээхэд хүч их шаарддаг хаах хэрэгслийг механик буюу цахилгаан хүчлүүрээр тоноглоно.

4.2.20. Газар дээрх хоолойг шатдаггүй материалаар хийсэн тулгуур дээр суурилуулна. Хоолойн байрлах өндөр тухайн нөхцөл байдлаас хамаарах боловч явган хүний зам дээгүүр 2,2 м, авто зам дээгүүр 4,5 м, төмөр зам дээгүүр 6 м-ээс намгүйгээр огтлолцно. Хоолойн тулгуур рельсээс 4,5 м, автозамын хашлагаас 1 м-ээс багагүй зайд байрлах ёстой.

4.2.21. Явган зам, автозам, төмөр замын дээгүүр гарч байгаа хоолойн хэсэгт хаах хэрэгсэл, фланцан буюу эрээсэн холболт, компенсатор байрлуулж болохгүй.

4.2.22. Хоолойн чиглэлийн эргэлтийн өнцөг 90^0 байх нь зүйтэй. Хоолой автозам, төмөр замтай 90^0 -ын өнцгөөр огтлолцох ба боломжгүй тохиолдолд огтлолцлын өнцөг 45^0 -аас багагүй байна.

4.2.23. Автозам, төмөр замын доогуур гарч байгаа шугам хоолойг хамгаалж гэр хоолой дотор байрлуулна. Гэр хоолойн үзүүр замын далангаас 0,5 м-ээс багагүй цухуйх ба ус орохоос хамгаалж чигжсэн байна. Гэр хоолой дотор байрласан шугам хоолойд гагнуурын оёдлын тоог аль болох цөөн байхаар угсарна. Гэр хоолойноос төмөр замын дэр хүртэл 1 м, автозамын хучилтын дээд гадаргуу хүртэл 0,8 метрээс багагүй байна.

4.2.24. Технологийн хоолойн дээгүүр хүн явах хэсэгт гарц, шат тавцан хийнэ.

4.2.25. Царцамтгай, зунгалаг өндөртэй бүтээгдэхүүн дамжуулах хоолойг гадна талаас зориулалтын халаах хэрэгслээр тоноглож болно.

4.2.26. Хоолойн гадна талыг зэврэлтээс хамгаалсан байна.

4.2.27. Технологийн хоолойг бүрэн суллаж системээс тусгаарласны дараагаар хоолойд засвар хийнэ.

4.2.28. Хоолойг ашиглахаас өмнө найдвартай газардуулсан байна. Фланцан холболтын боолтод цахилгаан дамжуулдаггүй материал ашигласан тохиолдолд тусгай металаар холбоно.

4.2.29. Ашиглалтын явцад хариуцсан ажилтан технологийн хоолойд тогтмол үзлэг хийж байна. Үзлэгийн хийх үечлэлийг агуулахын удирдлага тогтоох бөгөөд жилд дөрвөөс доошгүй удаа байна. Шалгалтын үед хоолойн доргионтой хэсэг, тулгууруудын байдалд онцгой анхаарал хандуулна.

4.2.30. Технологийн хоолойд 3 жил тутам шалгалт хийнэ. Шалгалтын хүрээнд хоолойн гадна болон дотор үзлэг хийнэ. Гадна үзлэгээр гагнуур оёдлуудын байдал, фланцан холболтууд, бүх холболтын битүүмжлэл, тулгуур, сууриудын байдал, компенсаторуудын ажиллагаа, хаах, хамгаалах хэрэгслүүдийн ажиллагааг шалгана. Дотор үзлэгийн хүрээнд зэврэлтийн хэмжээ, ан цав, хоолойн ханын нимгэрэлт, жийргүүдийг шалгана. Шалгалтын тухай акт үйлдэж илэрсэн согогуудыг холбогдох журмын дагуу засварлана.

4.2.31. Технологийн хоолойн бөх бат байдлыг даралтын туршилтаар шалгана. Туршилтыг ашиглалтын 3 жил тутамд буюу засвар хийх, тоног төхөөрөмж солих ажлын дараа хийнэ. Хоолойн туршилтын даралтыг дараах байдлаар тогтооно. Үүнд:

– хоолойн ажлын даралт 0,5 МПа-аас бага тохиолдолд ажлын даралтыг 50 хувиар нэмэгдүүлж, гэхдээ 0,2 МПа-аас багагүй,

– хоолойн ажлын даралт 0,5 МПа-аас илүү тохиолдолд ажлын даралтыг 25 хувиар нэмэгдүүлж, гэхдээ ажлын даралтыг 0,3 МПа-аар нэмэгдүүлснээс багагүй,

Туршилтын даралтыг 5 минут байлгаад ажлын даралт хэмжээнд хүртэл бууруулна. Туршилтын явцад манометрийн заалт буураагүй, хоолой, холболтуудад ямар нэг нүх сүв, согог илрээгүй нөхцөлд технологийн хоолойг туршилтад тэнцэнд тооцно. Туршилтын арга технологи аюулгүй ажиллагааг хангасан байна.

4.2.32. Технологийн хоолойд хийсэн үзлэг, шалгалт, засварын тухай тусгасан ашиглалтын баримт бичиг хөтөлнө.

4.2.33. Технологийн хоолойн битүүмжлэл, тулгуур, компенсаторуудын байдал, хамгаалах, хэмжих хэрэгслүүдийн ажиллагааг тогтмол хянаж илэрсэн эвдрэл гэмтлийг тухай бүр засаж байна.

4.2.34. Ашиглахгүй байгаа технологийн хоолой, хэсгүүдийг системээс салгаж аюулгүй байдлыг ханган битүүмжилнэ.

4.2.35. Технологийн хоолойн системийг хүйтний улиралд ашиглахын тулд усыг юүлэх, шаардлагатай тохиолдолд дулаалах, хаалт, төхөөрөмжүүдэд ус юүлэгч суурилуулах арга хэмжээ авна. Ашиглалтын явцад өндөр зунгалагтай буюу усжилт ихтэй бүтээгдэхүүн дамжуулсан хоолойг суллаж байна. Худгуудын усыг цэвэрлэж тагийн битүүмжлэлийг хангана.

4.2.36. Технологийн хоолойг үлээлгэх, уурдах, угаах, цэвэрлэх зэрэг зориулалтаар ашиглах хоолойг байнгын бус, салгадаг байдлаар хийх бөгөөд ажил дууссаны дараа салгаж авна.

4.2.37. Үйл ажиллагаа явагдаж байхад технологийн хоолойд засвар хийхийг хориглоно.

4.3. Насос станц

4.3.1. Бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, олгох, агуулахын дотоод шилжүүлэлт хийх зэрэг үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэх зориулалтын насос, холбогдох тоног төхөөрөмжүүд, тэдгээрийг байрлуулсан байгууламжийг насос станц гэнэ. Насос станцыг зураг төслийн дагуу барьж байгуулна.

4.3.2. Насос станц задгай болон битүү байж болно. Битүү насос станц агааржуулалтын зориулалтын системтэй байна.

4.3.3. Дээвэр доор байрласан задгай насос станцын хаших хийц байгалын агааржуулалт явагдах нөхцөлийг хангахуйц хэмжээний нүх, нээхийтэй байна.

4.3.4. Ашиглах насосууд бүтээгдэхүүний шинж чанарт тохирсон, галын аюулгүйн шаардлага хангасан байх ёстой. Насосын аюулгүй ажиллагааг хангахын тулд үйлдвэрлэгчийн заавар, холбогдох дүрэм журмын дагуу дохиолол, хамгаалалтын автомат системүүдээр тоноглоно.

4.3.5. Насосуудыг унтраах хэрэгслийг насос станцад байрлуулна.

4.3.6. Саванд байгаа бүтээгдэхүүний даралтаас сэргийлж насосын гаралт талд үл буцаах клапан тавина.

4.3.7. Бүтээгдэхүүний шахах хурдыг аюулгүй хэмжээнд тохируулахын тулд бүтээгдэхүүний зарим хэсгийг насосын гаралтын хоолойноос оролт тал руу шилжүүлэх холболтыг хийнэ.

4.3.8. Насос станцын хаалтуудын зангилааг насосоос тусгаарлаж дараах байрлалд байрлуулна. Үүнд:

- задгай суурилуулсан насосын талбайн зах буюу саравчнаас 5м,

- хаалга цонхгүй ханаас 1м, хаалга цонхтой ханаас 3м

Насос станцаас 10-15 м-ийн зайд насосын сорох болон шахах талд аваарын хаалтуудыг суурилуулна. Насос станцаас 50м хүртэлх зайд байрлаж байгаа технологийн хоолой, ачих буулгах төхөөрөмжийн хаалтуудыг аваарын хаалтын зориулалтаар ашиглахыг зөвшөөрнө.

4.3.9. Насос, насосын удирдлага, автоматжуулалтын тоног төхөөрөмжүүдийн байрлалыг сонгохдоо холбогдох нормын шаардлагыг баримтална.

4.3.10. Бүтээгдэхүүний галын аюулын зэрэглэлээс хамааруулж насос станцын барилгын аюулгүйн зэрэглэлийг тогтооно.

4.3.11. Насосын хөдөлгүүрийг насосоос ханаар тусгаарлан суурилуулсан тохиолдолд насосын голын ханыг нэвтэрч байгаа хэсгийг шатдаггүй материалаар битүүмжлэн чигжинэ.

4.3.12. Насос бүрийг агуулахын технологийн схемийн дагуу дугаарлах ба хөдөлгүүр дээр эргэлтийн чиглэл, оролт гаралтын хоолой дээр шингэний урсгалын чиг, удирдах хэрэгсэл дээр “асаах”, “унтраах” тэмдэглэгээ хийсэн байна.

4.3.13. Насос тус бүрт техникийн паспорт хөтөлж ажилласан хугацаа, хийсэн засварыг тэмдэглэнэ.

4.3.14. Насосуудыг хооронд нь 1 м-ээс багагүй зайтай суурилуулна. 0,6 м-ээс бага өргөн, 0,5 м-ээс нам насосуудын хооронд 0,7 м өргөн зай авч болно. Насосуудын эгнээ хооронд 1,5-м-ээс өргөн зайтай байна.

4.3.15. Насосын суурийг бүтээгдэхүүнээр бохирдож эвдрэхээс хамгаална.

4.3.16. Насос станцын шалыг бүтээгдэхүүнд тэсвэртэй, шингээдэггүй материалаар асгарсан бүтээгдэхүүн цуглуулах сувгийн чиглэлд налуутайгаар хийнэ. Насосын

4.3.17. Насосын тэвш, асгарсан бүтээгдэхүүн цуглуулах сувгийг илүүдлийн сав руу холбоно.

4.3.18. Насосын угсралт, тохируулга, туршилтыг зураг төсөл, үйлдвэрлэгчийн зааврын дагуу гүйцэтгэнэ. Насосын засвар, үйлчилгээг тогтоосон хуваарийн дагуу зохион байгуулах ба аюултай ажил гүйцэтгэх журмын дагуу засварын ажлыг хийнэ.

4.3.19. Насос станц дотор, харагдахуйц газар дараах баримт бичгийг байрлуулна. Үүнд:

- насосыг ашиглах заавар
- хөдөлмөр хамгааллын заавар
- галын аюулгүйн заавар
- насосын засвар үйлчилгээний хуваарь
- насосын технологийн схем
- цахилгааны холболтын схем

4.3.20. Насосын ашиглалтыг хариуцах ажилтныг удирдлагаас томилох ба ажилтан ашиглалтын баримт бичгийг хөтөлнө.

4.3.21. Насос станцад галын дохиолол, агаарын аюултай агууламжийн дохиоллын хэрэгсэл, аваарын унтраах төхөөрөмжийг зураг төслийн дагуу суурилуулна.

4.3.22. Насосыг ажиллуулж байх үед холбогдох ажилтан байнга хянах ба гэмтэл, зөрчил гарсан тохиолдолд насосыг унтрааж удирдлагад танилцуулна. Гэмтэл илэрсэн тохиолдолд бүрэн засварлаж, гэмтлийн шалтгааныг тогтоохоос өмнө ашиглахыг хориглоно.

4.3.23. Насосыг засварлах үед хаалтуудыг бүрэн хааж цахилгаан тэжээлээс салган удирдлагын самбар дээр “Асааж болохгүй” гэсэн сануулга байрлуулна.

4.3.24. Насосын өрөөнд агааржуулалтын хэрэгслийг зураг төслийн дагуу суурилуулна. Агааржуулалтын хэрэгсэл бүрэн бус тохиолдолд насосыг ажиллуулахыг хориглоно.

4.3.25. Насосыг удирдах хэрэгсэл өөр өрөөнд байрлаж байгаа тохиолдолд удирдлагын өрөө, насосын өрөөний хооронд шууд холбоо буюу дохиоллын хэрэгсэл ашиглана.

4.3.26. Цахилгаан тэжээл тасарсан тохиолдолд насосыг тэжээлээс салган бүх хаалтуудыг хаана.

4.4. Хийн тэнцвэржүүлэлтийн систем, хийн буцаах систем

4.4.1. Агуулахад их амьсгалын алдагдал, ууршилтыг багасгах, зорилгоор бензин хадгалах, ачих, буулгах ажиллагааг хамарсан хийн тэнцвэржүүлэлт, хийн буцаах системийг ашиглах нь зүйтэй. Савнуудын хийн орон зайг холбож нэгтгэсэн системийг хийн тэнцвэржүүлэлтийн систем, буулгах байгууламж, ачих байгууламжийг савны хийн орон зайтай холбосон системийг хийн буцаах систем гэнэ.

4.4.2. Хийн системүүдийг холбогдох норм дүрэм, зураг төслийн дагуу байгуулна,

4.4.3. Сав паркийг хийн тэнцвэржүүлэлтийн системээр тоногдсон тохиолдолд онгоцны бензиний савыг бусад бензинтэй савтай холбохыг хориглоно.

4.4.4. Хийн тэнцвэржүүлэлтийн системийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд дараах арга хэмжээг авна: Үүнд:

- саванд орлого авах, зарлага гаргах ажиллагааны зарцуулга, хугацааг харилцан уялдаатай байлгах аар зохицуулах,
- системийн битүүмжлэлийг бүрэн хангах,
- савны амьсгалах хэрэгслийг тогтмол шалгах,
- системээс хийн конденсатыг тогтмол юүлж байх,

4.4.5. Хийн тэнцвэржүүлэлтийн системд холбогдсон саванд гал гарсан тохиолдолд савыг системээс тусгаарлах зориулалтаар удирдлагатай хаах хэрэгсэл ашиглана.

4.4.6. Хийн тэнцвэржүүлэлтийн системд холбогдсон савыг ашиглалтаас хасах буюу өөр бүтээгдэхүүн хадгалах бол системээс салгана.

4.5. Вагонцистерний ачих буулгах байгууламж

4.5.1. Агуулахын хүчин чадлаас хамааруулан вагонцистернийг нэгээр буюу олноор зэрэг буулгах, ачих байгууламж ашиглана. Төмөр замын ачиж буулгах байгууламжийг зураг төслийн дагуу байгуулна.

4.5.2. Төмөр замын ачих буулгах байгууламжид дараах тоног төхөөрөмж байна. Үүнд:

- дээгүүр буюу доогуур буулгах хэрэгсэл
- насос /насос станц үгүй тохиолдолд/
- шат тавцан, цистернд дамжин гарах эвхдэг гүүрэн шат
- газардуулгын хэрэгсэл
- гэрэлтүүлэг
- гал унтраах хэрэгсэл
- холбооны хэрэгсэл
- аюулын үед вагонцистернийг зайлуулах хэрэгсэл
- вагонцистернийг хөдлөхөөс хамгаалах хэрэгсэл
- асгарсан бүтээгдэхүүнийг цуглуулах байгууламж

4.5.3. Ачиж буй вагонцистернийг суллах шаардлага гарсан тохиолдолд тусгай байр буюу ачих буулгах байгууламжид буулгах боломжтой байна.

4.5.4. Ачих буулгах байгууламжийг аянгын шууд ниргэлт, цахилгаан соронзон индукцээс хамгаалах арга хэмжээ авсан байна.

4.5.5. Буулгах байгууламжаас вагонцистерн руу тавигдах эвхдэг гүүрэн шат нь вагонцистернд тулах үзүүртээ оч үсрэхээс хамгаалсан жийрэгтэй байна.

4.5.6. Ачиж буулгах төхөөрөмж, хаалтуудыг технологийн схемийн дагуу дугаарлана.

4.5.7. Байгууламжийн тавцангийн үзүүрүүдэд, хоорондоо 100 м-ээс илүүгүй зайд тавцанд гарах шат байрлуулна. Шатыг шатдаггүй материалаар хийх ба шатны өргөн 0,7 м-ээс багагүй, өгсүүрийн налуу 45° градусаас илүүгүй байх ёстой.

4.5.8. Тоолуур, шүүлтүүр нь ашиглалтын нөхцөл, системийн даралт, хүчин чадал, бүтээгдэхүүний шинж чанарт тохирсон байна.

4.5.9. Ачих, буулгах төхөөрөмжийн битүүмжлэлийг 2 жилд нэгээс доошгүй удаа даралтаар шалгаж туршина.

4.5.10. Савнаас ачих төхөөрөмж рүү ирж байгаа шугам хоолой бүтээгдэхүүний марк тус бүрт тусгай байна.

4.5.11. Ачиж буулгах байгууламжийн эвдрэл гэмтэл, засварыг ашиглалтын баримт бичигт тэмдэглэнэ. Техникийн үзлэг, засвар, үйлчилгээг хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

4.6. Автоцистерний ачих буулгах байгууламж

4.6.1. Бүтээгдэхүүнийг автоцистернд ачих автоцистернээс буулгах байгууламжуудыг стандарт, норм дүрмийн шаардлагын хүрээнд зураг төслийн дагуу байгуулсан байна. Автоцистернээр шатахуун хүлээн авдаг агуулахад буулгах байгууламжийг ачих байгууламжтай хамт буюу тусгай байгуулна.

4.6.2. Автоцистернээс буулгах байгууламжид хүлээн авах сав, буулгах хэрэгсэл, автоцистерн зогсох бетон талбай, буулгах буюу хүлээн авах савнаас агуулахын сав руу шахах насос тээврийн хэрэгсэл дээр гарах шат тавцан, технологийн хоолой, газардуулгын холболт, тоолуур зэрэг холбогдох тоног төхөөрөмж суурилуулна.

4.6.3. Хүлээн авах сав нь нэг зэрэг хүлээн авах тээврийн хэрэгслийн нийт багтаамжаас багагүй багтаамжтай, сав дахь үлдэгдэл, бүтээгдэхүүн хүлээн авах орон зайг тодорхойлох боломжтой, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байх ёстой.

4.6.4. Автоцистернд ачих байгууламжид ачих гар, шат тавцан, бетон талбай, технологийн хоолой, тоолуур зэрэг холбогдох тоног төхөөрөмж хэрэгслүүд байна.

4.6.5. Ачих гар нь зориулалтын оч үсэргэдггүй металл хоолой буюу уян хоолой, оч үсэргэдэггүй материалаар хийсэн төгсгөвч, зориулалтын холбох хэрэгсэл, хөдөлгөх механизм, хаалт, бусад холбогдох төхөөрөмж хэрэгслээс бүрдэнэ. Дээгүүр ачих гарын хоолойн урт автоцистерний торхны ёроолд хүрхүйц урт байх ёстой.

4.6.6. Ачих гарт түргэн хаах хэрэгсэл байна.

4.6.7. Ачих буулгах байгууламжийн шат тавцан, саравч, хийц хэсгүүдийг шатдаггүй материалаар хийсэн байна.

4.6.8. Автоцистерний газардуулгыг чих буулгах байгууламжийн газардуулгын системд холбосон байх бөгөөд тасарсан тохиолдолд мэдээлэх буюу үйл ажиллагааг автоматаар зогсоох боломжтой байна.

4.6.9. Ачих байгууламжид тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэг урсгалтай, орох гарах зам саадгүй, хөдөлгөөний чиглэл заасан тэмдэг тэмдэглэгээтэй, ачих байрын дугаар заасан байна.

4.6.10. Автоцистернд бүтээгдэхүүн ачих үед халихаас хамгаалах автомат арга хэрэгсэл (хэт дүүргэлтийг мэдээлэх хэрэгсэл, тодорхой хэмжээг олгоод зогсдог автомат удирдлагатай шингэний тоолуур г.м) ашиглаагүй тохиолдолд асгарсан бүтээгдэхүүнийг цуглуулах систем байгуулна.

4.6.11. Шингэний цохилт, статик цэнэгжилт үүсэхээс сэргийлэх зорилгоор ачилт эхлэх болон дуусах үед шахалтын хурдыг багасгах боломжтой байна.

4.6. Агуулахын эдэлбэр газрын зохион байгуулалт, ашиглалт

4.6.1. Агуулахын эдэлбэр газарт байрлах барилга байгууламжуудын хоорондын зайг тэдгээрийн зориулалт, технологийн үйл ажиллагаа, галын болон тэсрэлтийн аюулын бүсүүд, барилга байгууламжийн гал тэсвэршлийн зэргээс хамааруулан аюул ослын үед эрсдэл хамгийн бага байхаар төлөвлөх бөгөөд БНБД 21-03-04 “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах. Галын аюулгүйн норм”, бусад холбогдох норм, шаардлагыг хангасан байна.

4.6.2. Агуулахын барилга байгууламж, технологийн үйл ажиллагааны зориулалтын байр, талбай, өрөө тасалгаа бүр дээр галын болон тэсрэлтийн аюулын зэрэглэл, бүсүүдийн хил заагийн тэмдэглэсэн байна. Галын болон тэсрэлтийн аюултай бүсийн ангилал, хил хязгаарыг БД 43-101-03 “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн дагуу, технологийн үйл ажиллагаа, өрөө тасалгааны галын аюулын зэрэглэлийг холбогдох норм, дүрмийн дагуу тогтооно.

4.6.3. Агуулахын замууд аюул осол гарсан үед техник хэрэгслийг аюултай бүсээс богино хугацаанд гаргах, гал унтраах техник хэрэгсэл саадгүй оруулах бололцоотой, БНБД 21-03-04-ын шаардлагыг хангасан байна.

4.6.4. Агуулахын эдэлбэр газрыг шатдаггүй материалаар хийсэн хашаагаар хамгаалсан байна. Хашааг захиргаа аж ахуйн барилга байгууламжаас бусад ангиллын барилга байгууламжаас 5 м-ээс багагүй зайд, тэсрэлтийн болон галын аюулгүйн бүсийн гадна байрлуулна. Агуулахын нутаг дэвсгэрт галын автомашин орж гарах зориулалтын 2–оос доошгүй хаалгыг төлөвлөсөн байна. Агуулахын хашаанд орох хүмүүст хяналт тавих боломжтойгоор хаалга, нэвтрэх байрыг тохижуулж гадны хүн агуулахын хашаанд зөвшөөрөлгүй нэвтрэхээс хамгаалсан байх ёстой.

4.6.5. Агуулахын удирдлага нь зэргэлдээ орших үйлдвэрийн газар, орон сууц, олон нийтийн барилга байгууламжаас агуулах хүртэлх аюулгүйн зай хэмжээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж, дурдсан зай хэмжээнээс ойр зайд ямар нэг барилга, байгууламж барих болон бусад аюултай үйл ажиллагаа эхэлбэл энэ тухай орон нутгийн захиргаа, гал түймэртэй тэмцэх байгууллага, барилга бариулагч буюу үйл ажиллагаа эрхлэгч этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

4.6.6. Агуулахын ерөнхий төлөвлөгөө, шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг төсөл байх ёстой. Газар доорх шугам сүлжээ, байгууламжийн дээр тодорхой тэмдэглэгээ хийнэ.

4.6.7. Агуулахын эдэлбэр газарт ил гал гаргахыг хориглоно. Гагнуурын болон гал хэрэглэх бусад ажлуудыг тусгайлан тоногдсон байр, талбайд хийнэ. Уг байр, талбайн байрлалыг галын байгууллагатай зөвшилцсөн байна.

4.6.8. Агуулахын эдэлбэр газар болон ажлын байрнууд нь шөнийн цагаар гэрэлтүүлэх галын аюулгүйн шаардлагыг хангасан гэрэлтүүлэгтэй байна. Харуул хамгаалалтын техник хэрэгсэл ашиглаж байгаа тохиолдолд гэрэлтүүлэх нөхцөлийг тухайн техник хэрэгслийн зааврын дагуу тодорхойлно.

4.6.9. Агуулахын чөлөөт газруудад навчит мод, бутлаг ургамал, зүлэг суулгахыг зөвшөөрөх бөгөөд савны далангийн гадна талаас 5 м-ээс багагүй зайд суулгасан байна.

4.6.10. Савны далангийн дотор талд мод, бутлаг ургамал суулгахыг хориглоно.

4.6.11. Агуулахын тэсрэмтгий болон шатамхай хий хуримтлагдаж болзошгүй газруудаар авто машин, трактор, мотоцикл болон бусад тээврийн хэрэгсэл зорчихыг хориглоно. Эдгээр газруудад хориглосон тэмдэг тавина. Агуулахын хашаанд орохоос өмнө хурдны хязгаарын тэмдэг, тээврийн хэрэгслийн явах замыг заасан схем байрлуулна. Агуулахаас тээврийн хэрэгсэл гарах, орох замууд огтлолцохгүй байхаар зохион байгуулах нь зүйтэй.

4.6.12. Бүтээгдэхүүн дамжуулах болон усан хангамж, ариутгах татуур, дулааны хангамжийн шугам хоолойн сүлжээ, цахилгааны утаснууд зэрэг газар доорхи байгууламж, зангилаа, худгуудын газар дээрх гадаргуу дээр тэдгээрийн холболтыг харуулсан тэмдэглэгээ хийсэн байна.

4.6.13. Галын тоног төхөөрөмж, гидрант зэрэгт очих зам, орцыг байнга чөлөөтэй байлгахын зэрэгцээ галын гидрант, усан сангийн ойролцоо түүнийг яаралтай олох бүдүүвчийг зурж байрлуулсан байна.

4.6.14. Агуулахын дэвсгэр нутагт орших зам талбай, гарам, салангад барилга байгууламжийн хоорондох галын аюулгүйн зайг элдэв байдлаар бөглөх, материал, тоног төхөөрөмж хадгалах зориулалтаар ашиглахыг хориглоно.

4.6.15. Өвлийн улиралд сав, технологийн талбай, агуулахын замуудын цасыг тухай бүр цэвэрлэж байна.

4.6.16. Дулааны улирал эхлэхээс өмнө үерийн ус зайлуулах байгууламж, хур тунадасны ус зайлуулах, цэвэрлэх системд шаардлагатай засвар хийнэ.

4.7. Агааржуулалтын систем

4.7.1. Ажиллагсдын аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөмжийн ашиглалтын нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор агуулахын технологийн үйл ажиллагаа явуулж байгаа өрөө тасалгаанд (цаашид өрөө гэх) агааржуулалтын систем ашиглана. Агааржуулалтын системийг холбогдох норм дүрэм, зураг төслийн дагуу байгуулж ашиглана.

4.7.2. Өрөөнд үүсэж байгаа хорт бодис, дулаан, чийгийн хэмжээ, агаар дахь тэсрэлтийн аюултай бодис, хорт бодисын зөвшөөрөгдөх агууламжийн нормыг үндэслэн агаар сэлгэлтийн солилцооны шаардлагатай хэмжээг тогтоосны үндсэн дээр агааржуулалтын системийн хүчин чадал, үзүүлэлтүүдийг сонгоно.

4.7.3. Өрөөнд хаягдаж байгаа хорт бодис, бүтээгдэхүүний уурын хэмжээг үйл ажиллагааны хэвийн үед туршилт, шинжилгээний аргаар тогтооно.

4.7.4. Хэрэв өрөөний агаарт хаягдах хортой бодисын хэмжээг тогтоох боломжгүй бол дараах хүснэгтийн дагуу агаар сэлгэх тоог тогтоохыг зөвшөөрнө.

Бүтээгдэхүүний төрөл	нэг цагт өрөөний агаарыг бүрэн сэлгэх тоо	
	хүхрийн нэгдэлгүй бүтээгдэхүүн	бүтээгдэхүүний уурын найрлагад 0,05 г/м ³ -аас дээш хүхрийн нэгдэл агуулагдаж байгаа үед
Бензин	6	8
Этилжүүлсэн бензин	13,5	13,5
Бензол	12	17
Дизелийн түлш, керосин, мазут	3	7
Тос, тосолгооны материал	3,3	5,5
Ажилласан тос	12	12

4.7.5. Хорт болон тэсрэлтийн аюултай бодис гэнэт их хэмжээгээр үүсэх магадлалтай буюу бусад шалтгаанаар тэсрэлтийн эрсдэл өндөртэй өрөөнд аваарын агааржуулалтын систем тавина. Аваарын систем нь аюул үүссэн нөхцөлд автоматаар ажиллаж аюул үүссэн тухай дохио өгдөг, гараар удирдах боломжтой байна. Аваарын систем өрөөний агаарыг цагт 8-аас доошгүй удаа сэлгэх хүчин чадалтай байна.

4.7.6. Агааржуулалтын тоног төхөөрөмжийн хийц нь тухайн өрөөний галын аюулын зэрэгт тохирч цахилгаан байгууламжийн дүрмийн шаардлагыг хангах ёстой.

4.7.7. Лабораторийн агааржуулалтыг зориулалтын сорох шүүгээнүүдээр хангана. Сорох шүүгээ байхгүй тохиолдолд өрөөний агаарыг цагт 3-аас доошгүй удаа сэлгэх агааржуулалтын систем ашиглана. Сорох шүүгээний агааржуулалтын хүчин чадлыг

шүүгээний багтаамж, хортой бодисын агаарт байх зөвшөөрөгдөх дээд агууламжийг үндэслэн тогтооно. Ажлын бус цагаар лабораторийг салхилуулах хэрэгтэй.

4.7.8. Агааржуулалтын үлээх системийн цэвэр агаар сорох хоолойд бүтээгдэхүүний уур орох боломжийг хаасан байна. Агаар сорж байгаа хэрэгслийг тогтмол шалгаж байх ёстой.

4.7.9. Агааржуулалтын сорох системийн агаар гаргаж байгаа орчимд хүмүүс ажиллах, салхийг хаах, тээврийн хэрэгсэл зогсоохыг хориглоно.

4.7.10. Агааржуулалтын системийг найдвартай газардуулна.

4.7.11. Агааржуулалтын системийг ашиглахаас өмнө туршиж тохируулга хийж ашиглалтын баримт бичигт тэмдэглэнэ.

4.7.12. Агааржуулалтын системийн ажиллагааг жилд хоёроос доошгүй тусгай хуваарийн дагуу шалгаж байна.

4.7.13. Агааржуулалтын системийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хийнэ.

4.7.14. Агааржуулалтын систем ажиллахгүй буюу шаардлагын түвшинд ажиллахгүй байгаа өрөөнд тоног төхөөрөмж ажиллуулах, хүн ажиллахыг хориглоно. Засварын ажил гүйцэтгэж байгаа хүмүүс хамгаалалтын тусгай хэрэгсэл ашиглах ба засварын ажлыг аюултай орчинд ажиллах журмын дагуу зохион байгуулна.

4.8. Ус хангамж, бохир ус зайлуулах систем

4.8.1. Агуулахын ус хангамжийн системийг зориулалтаас хамааруулан ахуйн хэрэглээний, технологийн зориулалтын гал унтраах зориулалтын гэж ангилна. Ус хангамжийн системийг барилгын норм дүрмийн хүрээнд зураг төслийн дагуу байгуулж холбогдох журам, зааврын дагуу ашиглана.

4.8.2. Ус хангамжийн системд усны эх үүсвэр, хотын шугам сүлжээ, агуулахын усны шугамууд, галын усан сан, гидрант, насосууд, хаалт бусад холбогдох тоног төхөөрөмж, барилга байгууламжууд хамаарна.

4.8.3. Агуулахын гал унтраах усны хэрэгцээг БНБД 21-03-04 “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах. Галын аюулгүйн норм”, бусад холбогдох норм дүрмийн дагуу тооцож усан санд хадгалах ус, бусад эх үүсвэрээс авах усны хэмжээг тогтооно.

4.8.4. Галын усан санд хадгалах усны хэмжээ, усны бусад эх үүсвэрийн бэлэн байдалд хариуцсан ажилтан байнгын хяналт тавьж байна.

4.8.5. Галын ус хангамжийн системийг бусад зориулалтын ус хангамжийн системээс тусгай төлөвлөж бүрэн бүтэн байдалд хяналт тавина. Галын усны системд засвар хийх тохиолдолд гал унтраах байгууллагатай тохиролцоно.

4.8.6. Галын усан сан, хоолойн системийг хүйтний улиралт хөлдөхөөс хамгаалах ба усны түвшинг байнга хянаж байна. Усан сангийн холболтын хэрэгслүүд, гал унтраах техник хэрэгслийн зам, гэрэлтүүлэг байнгын бэлэн байдалд байна.

4.8.7. Гал унтраах системийн насос, бусад цахилгаан тоног төхөөрөмжүүдийн цахилгаан тэжээл үл хамаарах хоёр тусгай эх үүсвэртэй байна. Цахилгаан тэжээлийн хоёр дахь эх үүсвэр байхгүй тохиолдолд дотоод шаталтат хөдөлгүүрээр насосыг ажиллуулж болно.

4.8.8. Гал унтраах системийн насос ашиглалтын байнгын бэлэн байдалд, төслийн хүчин чадлын хэмжээнд ажиллах боломжтой байна. Арав хоног тутам насосын ажиллагааг бүрэн хүчин чадлаар шалгаж дүнг ашиглалтын баримт бичигт тэмдэглэж байх ёстой.

4.8.9. Гал унтраах системийн насос станцад агуулахын галын усны хангалтын схем, гал гарсан үед ажиллах журмыг байрлуулж насос, тоног төхөөрөмж бүрийг схемийн дагуу дугаарлана.

4.8.10. Галын усны “хуурай” хоолой ашиглаж байгаа тохиолдолд жилд 2-оос доошгүй удаа ус шахаж шалгаж байна. Хуурай шугамыг ашигласны дараа усны үлдэгдлээс сайтар суллаж хатсаны дараа юүлэгчийг хаана.

4.8.11. Галын гидрантын байрлалын схемийг харагдахуйц газар байрлуулах ба гидрант байгаа газрыг заах тэмдгүүдийг байрлуулна.

4.8.12. Гидрантын худгийн тагийг хог шороо, цас мөснөөс байнга цэвэрлэж ямар ч үед онгойлгох боломжтой байлгана.

4.8.13. Ус хангамжийн системд гүний худаг ашиглах тохиолдолд усны гарц, насосын даралт, зарцуулга, усны шинж чанарыг тогтоосон хугацаанд шалгаж ашиглалтын зааврын дагуу зохион байгуулна.

4.8.14. Ус хангамжийн системийг өвлийн улиралд ашиглахад бэлтгэхийн тулд даралтаар шалгаж холбогдох засвар хийнэ. Галын усан сан, насос станцыг дулаалах, галын хуурай хоолойн усыг шавхах арга хэмжээ авна.

4.8.15. Агуулахын ахуйн хэрэглээний бохир ус зайлуулах шугамыг зураг төслийн дагуу байгуулж холбогдох дүрэм журмын дагуу ашиглалтын зохион байгуулна.

4.8.16. Бүтээгдэхүүнээр бохирдоогүй хур тунадасны усыг зайлуулах системийг холбогдох норм дүрэм, зураг төслийн дагуу байгуулж ашиглана.

4.8.17. Сав паркын далангийн доторх хур тунадасны усыг зайлуулах системийн хаах хэрэгслийг далангийн гадна байрлуулах бөгөөд байнгын хаалттай байлгана. Хуримтлагдсан хурын бохирдсон эсэхийг хянаж шаардлагатай тохиолдолд бохирдлын хэмжээг шинжлүүлэн цэвэрлэх эсэхийг шийдвэрлэнэ.

4.8.18. Савны даланд хуримтлагдсан бохирдоогүй усыг тухайн орон газрын хур тунадасны ус зайлуулах системд нийлүүлнэ. Бохирдсон усыг үйлдвэрлэлийн бохир ус цэвэрлэх байгууламжид нийлүүлнэ.

4.8.19. Технологийн үйл ажиллагааны хаягдал ус, бүтээгдэхүүн хадгалах савнаас авсан бохирдсон ус, лабораторийн хаягдал ус, технологийн талбайнуудад бохирдсон хур тунадасны ус зэрэг бохирдуулагч бодис агуулсан усыг цэвэршүүлэх зориулалтаар үйлдвэрлэлийн бохир усны систем ашиглана. Үйлдвэрлэлийн бохир усны системд цуглуулах суваг, худгууд, дамжуулах хоолой, цэвэрлэх байгууламж, насос станц, ууршуулах, тунгаах талбай, лагийн талбай зэрэг холбогдох барилга байгууламж тоног төхөөрөмжүүд багтана.

4.8.20. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хаягдаж байгаа ус, хур тунадасны усны нормативыг үндэслэн үйлдвэрлэлийн бохир усны системийн хүчин чадлыг тооцож 20 хувийн нөөц нэмэгдүүлж авна.

4.8.21. Усыг бохирдуулахыг багасгах, ус хэрэглээг бууруулах зорилгоор үйлдвэрлэлийн зориулалттай усыг дахин ашиглах систем ашиглах нь зүйтэй.

4.8.22. Бүтээгдэхүүн хадгалах сав цэвэрлэгээнээс гарсан усыг үйлдвэрлэлийн бохир усны системд нийлүүлэхээс өмнө механик хольц, тунадаснаас ялгана. Лабораторид хэрэглэсэн реактивыг үйлдвэрлэлийн бохир усны системд хаяхаас өмнө саармагжуулна.

4.8.23. Системд хаяж байгаа усны температур 40 °C-аас илүүгүй байна.

4.8.24. Үйлдвэрлэлийн бохир усны системийн худгуудыг технологийн талбайд байрлуулахыг хориглох ба худгууд байнгын хаалттай байна.

4.8.25. Үйлдвэрлэлийн бохир усны системийн дамжуулах хоолойнууд, худгуудыг жилд нэгээс доошгүй удаа цэвэрлэнэ. Цэвэрлэгээ засварын ажлыг аюултай ажил гүйцэтгэх журмын дагуу зохион байгуулна.

4.8.26. Үйлдвэрлэлийн бохир усны системээс хаягдаж байгаа усанд агуулагдаж байгаа бохирдуулагч бодисын хэмжээнд байнга хяналт тавьж байна. Хаягдал усны бохирдолт зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд шалтгааныг тодруулан системийн ажиллагаанд шалгалт хийнэ. Усны бохирдол, системийн ажиллагааг хянахын тулд ус цэвэршүүлэх системийн технологийн үе шат бүрт хяналт тавих нь үр дүнтэй.

4.8.27. Бохир усыг цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагааны явцад системд тэсрэлтийн аюултай холимог үүсэхээс сэргийлэх шаардлагатай.

4.8.28. Цэвэрлэх байгууламжийг өвлийн улиралд бэлтгэхийн тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- шугам, коллекторуудыг цэвэрлэх,
- насос, хаалтууд, хэмжих хэрэгслийг шалгах, тохируулах
- талбайнуудыг лагийн үлдэгдлээс цэвэрлэх

– тунгаах, ялгах худгуудыг цэвэрлэх

4.9. Лаборатори

4.9.1. Агуулахын лабораторийг зураг төслийн дагуу байгуулж шаардагдах тоног төхөөрөмжөөр хангана. Лабораторийг зохих журмын дагуу зөвшөөрөл авч холбогдох стандартын дагуу шинжилгээ хийнэ.

4.9.2. Лаборатори дараах шинжилгээг хийнэ.

- хүлээн авч, хадгалж, олгож байгаа бүтээгдэхүүний чанарын шинжилгээ
- цэвэрлэсэн үйлдвэрийн бохир ус
- гал хэрэглэсэн ажлын өмнөх агаарын шинжилгээ
- ажлын байрнуудын агаарын эрүүл ахуйн шинжилгээ
- агаарын бохирдлын шинжилгээ

4.9.3. Агуулахын лаборатори дээр заагдсан шинжилгээнүүдээс хийх боломжгүй тохиолдолд бусад байгууллагуудаар шинжлүүлнэ.

4.9.4. Лабораторийн үндсэн үүрэг

- холбогдох стандартын дагуу бүтээгдэхүүний чанарын паспорт олгох
- гал хэрэглэсэн ажил гүйцэтгэхийн өмнөх агаарын шинжилгээний дүнг өгөх
- үйлдвэрлэлийн хаягдал усанд байгаа бохирдуулагч бодисын агууламжийг тодорхойлсон шинжилгээний дүн гаргах
- ажлын байрны агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийг тодорхойлсон шинжилгээний дүн гаргах
- агуулахын орчны агаарын найрлагад байгаа бохирдуулагч бодис /нүүрсустөрөгч, хүхрийн исэл, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн давхар исэл, хүхэрт устөрөгч, хатуу бодис/-уудын агууламжийг тодорхойлсон шинжилгээний дүн гаргах,
- хяналтын дээжүүдийг хадгалах,
- бүтээгдэхүүнийг хэрэглэх тухай зөвлөгөө өгөх,

4.9.5. Лабораторийн багаж хэрэгсэл эвдрэл гэмтэлгүй байна. Эвдрэл гэмтэлтэй багаж хэрэгсэл ашиглан шинжилгээ хийхийг хориглоно.

4.9.6. Сорох шүүгээ, шинжилгээний ширээ ажлын байруудын хоорондын зам гарцуудыг аливаа зүйлээр хаахыг хориглоно.

4.9.7. Ажил эхлэхээс өмнө лабораторийн агааржуулна. Хортой буюу галын аюултай хий ялгарах шинжилгээг зөвхөн сорох шүүгээнд хийнэ.

4.9.8. Бүтээгдэхүүний үлдэгдэл, хортой бодисуудыг тусгай саванд юүлж лабораториос гаргана. Тэдгээрийг ахуйн бохир усны системд хаяхыг хориглоно.

4.9.9. Лабораторид бодисуудыг шинж чанараас нь хамааруулан ангилан тусгай хадгална. Шатамхай болон шаталт, тэсрэлт үүсгэдэг бодисуудыг хамт хадгалахыг хориглоно.

4.9.10. Галын аюултай бүтээгдэхүүн, бүтээгдэхүүнүүдийн дээж, хүчил, шүлтийг тусгайлан зориулсан байранд хадгална.

4.9.11. Зөвхөн тухайн өдрийн хэрэгцээнээс илүүгүй хэмжээний хялбар асах болон шатамхай шингэнүүдийг лабораторийн байранд байлгана. Эдгээрийг өрөөний гарах хаалганы эсрэг талд байрлуулсан металл шүүгээнд хадгална.

4.9.12. Шатамхай буюу хортой бодисыг халаах ажил гүйцэтгэх үед өрөөнд хоёроос доошгүй хүн байна. Шинжилгээ хийж байх үед ажлын байрыг орхихыг хориглоно.

4.9.13. Шинжилгээний ажлыг гүйцэтгэж байгаа ажилтан хөдөлмөр хамгааллын зориулалтын хувцас, хамгаалах хэрэгсэл ашиглана.

4.9.14. Лабораторийн өрөөг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

4.9.15. Шинжилгээний ажилд шаардлагатай дулаан гарган авахад цахилгаан эрчим хүч буюу шатдаг хийг ашиглах багажийг ашиглана.

4.9.16. Лабораторид ашиглаж байгаа хийн хангамжийн хэрэгслийг зохих журмын дагуу ашиглана.

4.9.17. Лабораторид эмнэлгийн анхан шатны тусламжийн хэрэгсэл байна.

4.10 Цахилгаан төхөөрөмж

4.10.1. Агуулахын цахилгаан эрчим хүчний хангамж найдваршилтийн 1 дүгээр зэрэглэлд хамаарах бөгөөд үл хамаарах хоёр эх үүсвэрээс тэжээгдэх ёстой. Тухайн орчинд цахилгаан эрчим хүчний түгээх сүлжээний үл хамаарах хоёр эх үүсвэр байхгүй бол хоёрдогч эх үүсвэрийн зориулалтаар өөрийн цахилгаан үүсгүүрийг ашиглаж болно.

4.10.2. Агуулахын гадна болон дотор цахилгаан хангамжийн системийг зураг төслийн дагуу байгуулах ба “Цахилгаан байгууламжийн дүрэм” БД 43-101-03-ын шаардлагыг хангасан байна.

4.10.3. Галын аюул гарсан үед ашиглах цахилгаан тоног төхөөрөмжүүдийн цахилгаан хангамж хоёр эх үүсвэрээс тэжээгдэнэ.

4.10.4. Цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор тэжээл тасарсан үед хоёрдогч эх үүсвэрт автоматаар холбох зориулалтын сэлгэн залгагч ашиглах нь зүйтэй.

4.10.5. Тэсрэлтийн болон галын аюултай бүсэд байрлах цахилгаан төхөөрөмж, автоматжуулалтын хэрэгслүүд тухайн бүсийн ангиллын дагуу шаардлага хангасан байна. Агуулахын В-1а ангиллын тэсрэлтийн аюултай бүсүүдэд тухайн бүсэд үүсэх тэсрэлтийн аюултай холимгийн зэрэглэлд тохирсон цахилгаан төхөөрөмж ашиглана.

4.10.6. Кабель шугамыг тавихдаа өндөр температур, бүтээгдэхүүн, ус чийг нөлөөлөх, механик гэмтэл үүсэх газраас зайлсхийнэ. Механик үйлчлэл, өндөр температурын нөлөөлөл байхгүй газруудад кабелийг ил тавих нь зүйтэй.

4.10.7. Тэсрэлтийн аюултай бүсүүдэд ил тавигдах кабелиуд механик гэмтлээс хамгаалсан хуяггүй бол шатдаггүй материалаар хийсэн хамгаалалтын хоолойд байрлуулна. Тэсрэлтийн аюултай В-1а ангиллын бүсэд зэс голтой кабель ашиглана.

4.10.8. Кабелийн муфтийг тэсрэлтийн аюултай өрөө тасалгаанд байрлуулахыг хориглоно.

4.10.9. Агуулахад “Цахилгаан байгууламжийн дүрэм” бусад холбогдох норм дүрмийн хүрээнд кабелийг технологийн хоолойтой нэг бүтээц, тулгуур дээр явуулахыг зөвшөөрнө.

4.10.10. Тэсрэлтийн аюултай бүсэд оруулгуудыг шатдаггүй материалаар битүүмжлэн чигжинэ.

4.10.11. Тэсрэлтийн аюултай бүсийн гадна, гадаа тавигдах цахилгаан төхөөрөмжүүд битүү буюу хагас битүү хийцтэй, цаг агаарын нөлөөнөөс хамгаалагдсан байна.

4.10.12. Агуулахын цахилгаан хангамжийн дотоод сүлжээнд 10/0,4 болон 6/04 кВ хүчдэлийн трансформаторын дэд өртөөнүүд, хуваарилах самбарууд, дамжуулах сүлжээнүүд хамаарна. Гадна болон дотоод сүлжээний үйлчилгээний заагийг цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллагатай тохиролцож шийдвэрлэнэ.

4.10.13. Ашиглалтанд байгаа цахилгаан төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажил зохион байгуулахад холбогдох аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтална.

4.10.14. Цахилгаан хангамжийн сүлжээний ашиглалт хариуцсан ажилтан дараах арга хэмжээг авна. Үүнд:

- цахилгаан төхөөрөмж, сүлжээний үзлэг, засварыг цаг тухайд нь зохион байгуулах, эвдрэл гэмтлийг тухай бүр засварлах,
- тэсрэлтийн болон галын аюултай бүс, өрөө тасалгаанд суурилагдсан цахилгаан төхөөрөмж тухайн ангиллын шаардлага хангаж байгаад хяналт тавих,
- богино холболт, хэт ачаалал, дотоодын болон гадна хэт хүчдэл болон бусад хэвийн бус нөхцөлөөс хамгаалах зориулалтын хэрэгслүүдийн ажиллагаанд тогтмол хяналт тавих,

4.10.15. Хүчний болон удирдлагын кабелиудын бүрээсийн байдалд үзлэг хийх, контактуудын найдвартай байдал, газардуулгын төхөөрөмжийн эсэргүүцэл, цахилгаан хөдөлгүүрүүд, хамгаалалтын төхөөрөмжүүдийн ажиллагааг шалгах, төлөвлөгөөг баталж мөрдөнө.

4.10.16. Цахилгаан төхөөрөмжүүдийн үзлэгийн дүн, хийсэн засварын талаар ашиглалтын баримт бичигт тэмдэглэнэ.

4.10.17. Цахилгаан төхөөрөмжийн засвар үйлчилгээг гүйцэтгэх хүмүүс хамгаалах хэрэгсэл, тусгай багажаар хангагдана.

4.10.18. Тэсрэлтийн аюултай бүсүүдэд түр хугацаагаар ашиглах гэрэлтүүлэгч, цахилгаан төхөөрөмжүүд нь тэсрэлтийн хамгаалалттай байна.

4.11 Удирдлага, хяналт, автоматжуулалтын систем

4.11.1. Агуулахын технологийн үйл ажиллагааны удирдлага хяналтын системийг холбогдох норм дүрмийн хүрээнд зурагт төслийн дагуу байгуулна.

4.11.2. Автоматжуулалтын түвшин, хамрах хүрээг тодорхойлохдоо аваар ослоос сэргийлэх, ажиллагсдын аюулгүй байдлыг хангах, технологийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлд холбогдох норм дүрмийн шаардлагуудыг үндэслэл болгоно.

4.11.3. Удирдлага, хяналт, автоматжуулалтын системийн цахилгаан төхөөрөмжүүд “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн шаардлагыг хангах ёстой.

4.11.4. Удирдлага хяналт, дохиоллын системийн цахилгаан удирдлагын төхөөрөмжүүдийг “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн шаардлагыг хангасан аюулгүй газар байрлуулна. Гадаа агаарт байрлуулах боломжгүй хэмжих, хянах хэрэгслүүдийг дулаалгатай шүүгээнд байрлуулж болно.

4.11.5. Технологийн үйл ажиллагааны автомат системийг төвлөрсөн байр, өрөө тасалгаанаас удирдана.

4.11.6. Удирдлагын байранд галын болон аюултай орчны мэдээлэгчүүдийн дохиолуудыг байрлуулна.

4.11.7. Удирдлага, хяналтын системийн тоног төхөөрөмжүүд эвдрэлтэй буюу салгасан үед технологийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг хориглоно.

4.11.8. Системд засвар хийж байгаа үед технологийн үйл ажиллагааг гар удирдлагаар явуулж болох ба энэ тохиолдолд тусгай зааварчилга гаргаж ажиллагсдын гүйцэтгэх үүргийг тодорхой заана.

4.11.9. Технологийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн хэмжилтийн нарийвчлалыг шаардлагын түвшинд байлгахын тулд хэмжилт хийх арга, хэмжүүрүүдийг хянах, тэдгээрийн эвдрэл гэмтлийг оношлох үйл ажиллагааг стандарт, заавруудын дагуу гүйцэтгэнэ.

4.11.10. Агуулахад бүтээгдхүүнийг хадгалах, хоолойгоор дамжуулах технологийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх дээд хязгаарыг тогтоож технологийн зааварт оруулан мөрдөнө.

4.12. Аяндын хамгаалалт

4.12.1. Агуулахын барилга байгууламжуудын аяндын хамгаалалтыг зураг төслийн дагуу холбогдох норм дүрмийн шаардлагыг хангаж хийнэ.

4.12.2. Аянга хамгаалах хэрэгслийн жижиг засварыг эвдрэл гарах тутам хийх ба их засварыг зөвхөн аянга буудаггүй үеэр зохион байгуулна. Аяндын хамгаалалтын хэрэгслийн угсралт буюу засварын ажил гүйцэтгэсний дараа шалгалт хийж акт үйлдэнэ.

4.12.3. Ашиглалтын үед аянгаас хамгаалах хэрэгслийг аяндын улирал эхлэхээс өмнө болон тодорхой үечлэлээр шалгана. Шалгалтаар дараах арга хэмжээг авна. Үүнд:

- механик гэмтлийг илрүүлэх
- гүйдэл дамжуулагчуудын холболтын бүрэн бүтэн байдлыг шалгах
- зэврэлтийн хэмжээг тодорхойлох, зэврэлтээс хамгаалах бүрхүүлийг шалгах

4.12.4. Аяндын хамгаалалтын газардуулгуудын эсэргүүцлийг жил бүр шалгах ба эсэргүүцэл ихэссэн тохиолдолд шаардагдах хэмжээнд хүргэх арга хэмжээ авна.

4.13. Статик цэнэгжилтээс хамгаалах

4.13.1. Агуулахын технологийн үйл ажиллагааны явцад үүсэх статик цахилгаан цэнэгжилтийн нөлөөнөөс хамгаалах хэрэгслийг зураг төслийн дагуу байгуулж аюулгүй ажиллагааны арга хэмжээг холбогдох дүрэм зааврын дагуу зохион байгуулна.

4.13.2. Статик цэнэгжилтээс үүсэж болох аюулаас сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авна. Үүнд:

- сав, вагонцистерн, насос, төмөр замын рельс, автоцистерн, технологийн хоолой, ачих буулгах төхөөрөмж, хэмжүүр, дээж авах хэрэгслүүдийг газардуулах,
- бүтээгдэхүүний цахилгаан дамжуулах чанарыг нэмэгдүүлдэг хольц хэрэглэх,
- бүтээгдэхүүнийг ачих, шугам хоолойгоор дамжуулах хурдыг бууруулах,
- цэнэгийг саармагжуулах арга хэрэгсэл ашиглах

4.13.3. Статик цэнэгийн газардуулгын хэрэгслийг холбогдох норм дүрмийн дагуу хийж цахилгаан төхөөрөмжийн газардуулга, аянгын хамгаалалтын газардуулгатай холбоно. Зөвхөн статик цэнэгжилтийн зориулалттай газардуулгын эсэргүүцэл 100 Ом-оос хэтрэхгүй байна.

4.13.4. Цахилгаан цэнэгжилтээс хамгаалах өөр арга хэмжээ авсан эсэхээс үл хамааран технологийн тоног төхөөрөмжийн металл болон цахилгаан дамжуулах чадвартай металл бус хэсгүүдийг газардуулна.

4.13.5. Металл болон цахилгаан дамжуулагч металл бус тоног төхөөрөмжүүд, технологийн хоолой, хоолойн дулаалгын хамгаалалт зэрэг нь холбогдсон бүх уртын хэмжээнд тасралтгүй үргэлжилсэн цахилгаан хэлхээ болох ёстой бөгөөд 40-50 м тутамд буюу хоёроос доошгүй цэгээр газардуулгын сүлжээнд холбоно.

4.13.6. Хөдөлгөөнгүй суурилагдсан металл бүтээцүүдийг (сав, технологийн хоолой г.м) хооронд нь болон газардуулгад холбоход 48 мм^2 -аас багагүй хөндлөн огтлолтой туузан ган буюу 6 мм-ээс багагүй голчтой ган утсыг ашиглана. Бүх холболтыг гагнуураар буюу боолтоор хийнэ.

4.13.7. Металл төхөөрөмжийн будагтай гадаргууд холбосон газардуулгын холболтын эсэргүүцэл 10 Ом-оос илүүгүй байвал газардуулсанд тооцно.

4.13.8. Резин хоолойг газардуулахдаа 6 мм^2 -аас багагүй хөндлөн огтлолын зэс уян дамжуулагчийг ган спиральтай хоолойн төгсгөвчид холбох ба хоолой спиральгүй тохиолдолд дамжуулагчийг хоолой дотуур гүйлгэж төгсгөвчүүдтэй холбоно.

4.13.9. Ачилт буюу буулгалт хийх автоцистерн, вагонцистерний люк онгойлгох, ачих буулгах хэрэгсэлд холбох ажиллагааг тэдгээрийг газардуулгад холбосны дараа гүйцэтгэх ба ачих, буулгах үйл ажиллагааны бүх хугацаанд газардуулгыг салгахгүй. Газардуулгын холбох хэрэгслийг автоцистерн, вагонцистерний зориулалтын хэрэгсэлд холбох бөгөөд будагтай буюу бохирдсон гадаргууд холбохыг хориглоно.

4.13.10. Ачих буулгах төхөөрөмжийн цахилгаан дамжуулдаггүй материалаар хийсэн хоолой оч үсэргэдэггүй металл төгсгөвчтэй байх ба төгсгөвчийг төхөөрөмжийн газардуулсан металл хэсэгт холбосон дамжуулагчтай байна.

4.13.11. Цистернд бүтээгдэхүүнийг ачихдаа цацруулах, асгах, хүчтэй холилт үүсгэхийг хориглоно. Ачих хоолойн үзүүрээс торхны ёроол хүртэлх зай 0,2 м-ээс илүүгүй байх ба эхний үед дээрх зайг барих боломжгүй нөхцөлд шингэний урсгалыг торхны ханыг дагуулахаар тохируулна.

4.13.12. Бүтээгдэхүүнийг ачих, саванд юүлэх үед шахаж байгаа бүтээгдэхүүнээр дамжин аюултай цэнэгжилт үүсэж оч гарахаас сэргийлэхийн тулд шахах хурдыг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлж болохгүй. Бүтээгдэхүүн шахах зөвшөөрөгдөх дээд хурдны хэмжээг бүтээгдэхүүн тус бүрт холбогдох зааврын дагуу тооцож тодорхойлно.

4.13.13. Хоосон саванд бүтээгдэхүүн юүлэх үед савны орлогын хоолой шингэний түвшин дор бүрэн ортол бүтээгдэхүүнийг шахах хурд 1 м/с-ээс илүүгүй байна.

4.13.14. Цахилгаан дамжуулдаггүй материалаар хийсэн хөвүүрийг холбогдох зааврын дагуу статик цэнэгжилтээс хамгаална.

4.13.15. Савнаас гар аргаар дээж авах ажиллагааг саванд бүтээгдэхүүн шахах үйл ажиллагаа зогссоноос хойш 10 минутаас багагүй хугацаа өнгөрсний дараа эхэлнэ. Дээж авагчийг уян зэс дамжуулагчаар савны аль нэг хэсэгт зориулалтын хавчаараар холбож газардуулна.

4.13.16. Статик цэнэгжилтээс хамгаалах газардуулгын үзлэг, урсгал засварыг технологийн болон цахилгаан тоног төхөөрөмжийн үзлэг засвартай хамтатган зохион байгуулах нь зүйтэй. Газардуулгын эсэргүүцлийг жилд нэгээс доошгүй удаа хэмжиж акт үйлдэнэ.